



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 30-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ГАЗАР

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

2025 оны 12 дугаар сарын 30-ны өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-8
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	9-51

1.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 09 дүгээр дүгнэлт /Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74.2.2, 74.2.3, 74.2.4, 74.3.2, 74.3.3, 74.3.4, 74.3.5 дахь заалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай/	10-16
2.Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнийг томилох тухай асуудал	18-25
3.“Монгол Улсын Эрдэнэсийн сангийн үндсэн сангийн орлого, гүйлгээ сангийн орлого, зарлагын 2025 оны гүйцэтгэл, 2026 оны төсвийн тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /үргэлжлэл/	25
4.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 10 дугаар дүгнэлт /Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйл Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай/	25-47
5.“Чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл	47-50
6.Баталсан тогтоолын эцсийн найруулгыг танилцуулах	50-51

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
12 дугаар сарын 30-ны өдөр /Мягмар гараг/-ийн
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Н.Учрал ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 76 гишүүн хүрэлцэн ирж, 60.3 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 49 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: О.Амгаланбаатар, Д.Батбаяр, Б.Батцэцэг, Т.Доржханд, Ц.Идэрбат, Л.Мөнхбаатар, Б.Пүрэвдорж, Ц.Туваан;

Чөлөөтэй: О.Алтангэрэл, Д.Амарбаясгалан, С.Амарсайхан, Э.Бат-Амгалан, Х.Баттулга, П.Батчимэг, Б.Баярбаатар, Ш.Бямбасүрэн, Д.Ганмаа, М.Нарантуяа-Нара, Ч.Номин, О.Номинчимэг, Н.Номтойбаяр, Э.Одбаяр, С.Одонтуяа, Л.Оюун-Эрдэнэ, Б.Пунсалмаа, Д.Цогтбаатар, Д.Энхтүвшин;

Эмнэлгийн чөлөөтэй: Д.Батлут, Ж.Баясгалан, Х.Болормаа, Х.Булгантуяа, Ж.Ганбаатар, Л.Гантөмөр, С.Лүндэг, М.Мандхай, Б.Мөнхсоёл, П.Мөнхтулга, Б.Тулга, Б.Уянга, Б.Чойжилсүрэн, Р.Эрдэнэбүрэн;

Тасалсан: Ж.Батсуурь, М.Ганхүлэг, Б.Жавхлан, Д.Пүрэвдаваа;

Хоцорсон: Ж.Алдаржавхлан-23 минут, М.Бадамсүрэн-34 минут, Д.Ганбат-2 цаг 26 минут, Б.Дэлгэрсайхан-07 минут, Ч.Лодойсамбуу-50 минут.

Өргөн мэдүүлсэн төслийн талаар мэдээлэх

Улсын Их Хурлын дарга Н.Учрал Монгол Улсын Засгийн газраас 2025.12.26-ны өдөр өргөн мэдүүлсэн Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Австри Улс хоорондын хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хуваарилсныг мэдээлэв.

Нэг.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 09 дүгээр дүгнэлт /Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74.2.2, 74.2.3, 74.2.4, 74.3.2, 74.3.3, 74.3.4, 74.3.5 дахь заалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүн О.Мөнхсайхан оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга П.Батбаатар, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Ж.Бямбадулам нар байлцав.

Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцийн гишүүн О.Мөнхсайхан танилцуулав.

Дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт асууж, үг хэлээгүй болно.

Улсын Их Хурлын гишүүд Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 09 дүгээр дүгнэлттэй танилцлаа.

Уг асуудлыг 15 цаг 10 минутад хэлэлцэж дуусав.

Хуралдаан 15 цаг 11 минутаас 17 цаг 25 минутад завсарлав.

Улсын Их Хурлын дарга Н.Учрал Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлаар Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлэг Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаас ажлын 5 өдрийн завсарлага авсан тул хэлэлцэх асуудлын дарааллаас хасагдсан талаар мэдэгдэж, үг хэлэв. /17:32/

Хоёр.Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнийг томилох тухай асуудал

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшигч Ч.Баянжаргал, Х.Эрдэм-Ундрах нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга П.Батбаатар, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Ж.Бямбадулам, мөн газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Д.Нямбаяр нар байлцав.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшүүлэх тухай асуудлыг хэлэлцсэн талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа танилцуулав.

Нэр дэвшигч болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд, Г.Уянгахишиг, С.Эрдэнэбат нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнийг томилох санал хураалтыг нууцаар, цахимаар явуулах горимын санал гаргав.

Н.Учрал: Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргалын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 29
Татгалзсан: 52

Бүгд: 81
35.8 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Н.Учрал: Байнгын хорооны саналаар Хүрэлбаатарын Эрдэм-Ундрахыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 58
Татгалзсан: 23
Бүгд: 81
71.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Н.Учрал: Байнгын хорооны саналаар Чадраабалын Баянжаргалыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 54
Татгалзсан: 27
Бүгд: 81
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсенгийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр “хуралдааны тэмдэглэлд” тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 81 гишүүнээс 55 гишүүн дэмжиж, 67.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул “Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнээр томилох, чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцов.

“Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнээр томилох, чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Эцсийн найруулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг үг хэлэв. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа. /17:58/

Уг асуудлыг 17 цаг 59 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.*“Монгол Улсын Эрдэнэсийн сангийн үндсэн сангийн орлого, гүйлгээ сангийн орлого, зарлагын 2025 оны гүйцэтгэл, 2026 оны төсвийн тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /үргэлжлэл/*

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга П.Батбаатар, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Ж.Бямбадулам, мөн газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, зөвлөх Л.Батмөнх, референт М.Мандхай нар байлцав.

Н.Учрал: Байнгын хорооны саналаар “Монгол Улсын Эрдэнэсийн сангийн үндсэн сангийн орлого, гүйлгээ сангийн орлого, зарлагын 2025 оны гүйцэтгэл, 2026

оны төсвийн тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 48

Татгалзсан: 33

Бүгд: 81

59.3 хувийн саналаар Улсын Их Хурлын тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 18 цаг 00 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 10 дугаар дүгнэлт /Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйл Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Үндсэн хуулийн цэцийн гишүүн О.Мөнхсайхан оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга П.Батбаатар, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Ж.Бямбадулам, мөн газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Д.Нямбаяр нар байлцав.

Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцийн гишүүн О.Мөнхсайхан, Цэцийн дүгнэлтийг хэлэлцсэн талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал нар танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин, Б.Батбаатар нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр, Улсын Их Хурлын дарга Н.Учрал нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалан, А.Ариунзаяа, А.Ганбаатар, Б.Жаргалан, Ж.Золжаргал, Х.Баасанжаргал нар үг хэлэв.

Байнгын хорооноос гаргасан санал тус бүрээр санал хураалт явуулав.

Н.Учрал: 1.Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлд “Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараасан бол дөрвөн зуун тавин нэгжээс нэг мянга гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас гурван сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “... эрх чөлөө, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэснийг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэсэн Байнгын хорооны саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 71

Бүгд: 81
12.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

2.Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлд “Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараасан бол дөрвөн зуун тавин нэгжээс нэг мянга гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас гурван сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 16 дахь заалтын “... үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх ... эрх чөлөөтэй. ...” гэснийг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэсэн Байнгын хорооны саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 71
Бүгд: 81
12.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

3.Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлд “Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараасан бол дөрвөн зуун тавин нэгжээс нэг мянга гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас гурван сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 17 дахь заалтын “төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. ...” гэснийг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэсэн Байнгын хорооны саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 70
Бүгд: 81
13.6 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

4.Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлд “Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараасан бол дөрвөн зуун тавин нэгжээс нэг мянга гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас гурван сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Үндсэн хуульд хууль ... бүрнээ нийцсэн байвал зохино.” гэснийг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэсэн Байнгын хорооны саналыг дэмжье гэж санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 73
Бүгд: 81

9.9 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрсөн тул “Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 10 дүгнэлтийн тухай” Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцов.

Уг асуудлыг 19 цаг 17 минутад хэлэлцэж дуусав.

Тав. “Чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга П.Батбаатар, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Ж.Бямбадулам, мөн газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, зөвлөх Б.Нандингэрэл, референт М.Мандхай нар байлцав.

Төслийг хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Н.Учрал: Байнгын хорооны саналаар “Чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 46
Татгалзсан: 35
Бүгд: 81
56.8 хувийн саналаар Улсын Их Хурлын тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 19 цаг 26 минутад хэлэлцэж дуусав.

Зургаа. Баталсан тогтоолын эцсийн найруулгыг танилцуулах

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга П.Батбаатар, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Ж.Бямбадулам, мөн газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, зөвлөх Б.Нандингэрэл, референт М.Мандхай нар байлцав.

Улсын Их Хурлын дарга Н.Учрал дараах тогтоолуудын эцсийн найруулгыг танилцуулав. Үүнд:

1. “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Эцсийн найруулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн үг хэлэв. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа. /19:27/

2. “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын

тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа. /19:28/

3.“Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа. /19:28/

4.“Оюу толгой бүлэг ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах, хүртэх өгөөжийг нэмэгдүүлэх хүрээнд хийсэн тусгай шалгалт, нээлттэй сонсголын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа. /19:29/

Уг асуудлыг 19 цаг 30 минутад хэлэлцэж дуусав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 6 асуудал хэлэлцэв.

Бусад. Улсын Их Хурлын дарга Н.Учрал төрсөн өдөр нь тохиож байгаа Улсын Их Хурлын гишүүн Б.Батбаатарт Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс баяр хүргэж, эрүүл энх, аз жаргал, сайн сайхныг хүсэн ерөөв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуралдаан зохион байгуулах газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын шинжээч С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 2 цаг 27 минут үргэлжилж, 126 гишүүнээс 81 гишүүн хүрэлцэн ирж, 64.3 хувийн ирцтэйгээр 19 цаг 30 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН

БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ

ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

**2025 оны 12 дугаар сарын 30-ны өдөр, Мягмар гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
14 цаг 49 минут**

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Н.Учрал: Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы 12 дугаар сарын 30-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Өнөөдрийн хуралдаанаар

“Монгол Улсын Эрдэнэсийн сангийн үндсэн сангийн орлого, гүйлгээ сангийн орлого, зарлагын 2025 оны гүйцэтгэл, 2026 оны төсвийн тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үргэлжлүүлэн хэлэлцэнэ.

2 дугаарт, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 09 дүгээр дүгнэлтийг хэлэлцэнэ.

3 дугаарт, Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнийг томилох тухай асуудлыг хэлэлцэнэ.

4 дүгээрт, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 10 дугаар дүгнэлтийг хэлэлцэнэ.

5 дугаарт, “Чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

6 дугаарт, Баталсан тогтоолын эцсийн найруулгыг сонсоно.

Чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу санал хураалтыг нэгтгээд явуулъя.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 29.1-д Улсын Их Хурлын дарга хууль санаачлагчаас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх Байнгын хороог, хэрэв тухайн тэр төсөл хэд хэдэн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарахаар бол зөвлөлтэй зөвшилцөн холбогдох болон бусад Байнгын хороог тогтоож, нэгдсэн хуралдаанаар мэдээлнэ гэж заасан.

Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хуулийн төслийг холбогдох Байнгын хороонд хуваарилсан талаар танилцуулъя.

Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Австри Улсын хооронд хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Засгийн газар

2025 оны 12 дугаар сарын 26-ны өдөр өргөн мэдүүлснийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хуваарилсныг та бүхэнд танилцуулъя.

Хэлэлцэх асуудалдаа оръё. Эрдэнэсийн сангийн орлогын талаар санал хураалтыг нэгтгээд явуулна. Дараагийн асуудлыг шууд хэлэлцье.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 09 дүгээр дүгнэлт
/Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74.2.2, 74.2.3, 74.2.4, 74.3.2, 74.3.3, 74.3.4, 74.3.5 дахь заалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай/

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 09 дүгээр дүгнэлт. /Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74.2.2, 74.2.3, 2.4, 3.2, 3.3, 3.4, 3.5 дахь заалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэгдсэн тухай/ Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хэлэлцэнэ.

Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцийн гишүүн Одонхүүгийн Мөнхсайхан танилцуулна. Үндсэн хуулийн цэцийн гишүүн Мөнхсайханыг индэрт урья.

Үндсэн хуулийн цэцийн гишүүн Одонхүүгийн Мөнхсайхан таныг индэрт урьж байна.

О.Мөнхсайхан: Монгол Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Та бүхэнд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 09 дүгээр дүгнэлтийг танилцуулж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн дарга Г.Баясгалан даргалагч, Үндсэн хуулийн цэцийн гишүүн Ж.Эрдэнэбулган, Д.Гангабаатар, О.Мөнхсайхан, илтгэгч Ц.Цолмон нарын бүрэлдэхүүнтэй хуралдааны Нарийн бичгийн даргаар Б.Баяржаргалыг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Дунд суудлын хуралдаанд өргөдөл, мэдээлэл гаргагч иргэн А.Отгонбаатар, Б.Отгон, Г.Батбаяр, Т.Баярхүү, Д.Лхамжав, К.Жандосын өмгөөлөгч С.Асланбек, Ө.Баяраагийн итгэмжилсэн төлөөлөгч М.Зулзаяа, Б.Бат-Үүл болон Монгол Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг, мөн шинжээчээр Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн дэд профессор, Улс төр судлалын доктор Э.Гэрэлт-Од нар оролцлоо.

Энэхүү хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74.2.2, 74.2.3, 74.2.4, 74.3.2, 74.3.3, 74.3.4, 74.3.5 дахь заалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан хэлэлцэв.

Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 09 дүгээр дүгнэлт нь нийт 36 хуудас, түүний үндэслэл хэсэг нь дангаараа 25 хуудас учраас дүгнэлтийн үндэслэл хэсгийг товчилж тогтоох хэсгийг бүхэлд нь уншиж сонсгоё.

Үндэслэл

Ардчилсан нийгэмд сонгууль нь санал хураалт явуулах замаар нийтийн албан тушаал эрхлэх хүнийг сонгох үйл явц бөгөөд энэ нь улс төрийн шийдвэр гаргах түвшин дэх сонгогчдын оролцоо, төлөөлөл, нийгмийн зөвшилцлийг хангахад чиглэдэг ардчилсан сонгуулийн зарчмын дагуу явуулсан сонгуульгүйгээр ардчилсан нийгэм оршин тогтнох боломжгүй. Үндсэн хуульд иргэд нийтээрээ, чөлөөтэй, тэгш, шууд сонгох, саналаа нууцаар гаргах зэрэг ардчилсан сонгуулийн зарчмыг тусгасан бөгөөд иргэн бүр сонгуульд оролцох тэгш боломжоор хангагдах ёстой. Эдгээр зарчим нь сонгогчдын хүсэл зоригийн чөлөөт илэрхийллийг баталгаажуулж, ардчилсан сонгууль явуулах суурь нөхцөлийг тогтоож өгдөг.

1990 оноос хойш парламентын сонгуулийг нийт 10 удаа зохион байгуулжээ. Тухайлбал, 1992-2020 оны хооронд Улсын Их Хурлын нийт 8 удаагийн сонгууль явуулснаас 7-г нь олныг төлөөлөх тогтолцоогоор, үүний 4 нь 1 мандаттай, 3 нь олон мандаттай тойргоор, харин 1 сонгууль нь холимог тогтолцоогоор зохион байгуулагдсан байна.

Энэ хугацаанд Улсын Их Хурлыг 8 удаа байгуулахдаа сонгуулийн тогтолцоог тухай бүр өөрчилж, өөрчлөлт бүр нь ээлжит сонгуулиас 1-6 сарын өмнө хийгдэж байжээ.

Иймээс сонгуулийн тогтолцооны тогтвортой байдлыг хангах, намууд сонгуульд шударгаар өрсөлдөх, олон намын тогтолцоог бэхжүүлэх үүднээс олныг төлөөлөх болон хувь тэнцүүлэн төлөөлөх аргын давуу талыг тусгасан сонгуулийн холимог тогтолцоог 2023 оны өөрчлөлтөөр Үндсэн хуульд тусгасан байна.

Тодруулбал, Улсын Их Хурлын 126 гишүүний 78-ыг нь олныг төлөөлөх, 48-ыг нь хувь тэнцүүлэн төлөөлөх аргаар сонгох ерөнхий харьцааг Үндсэн хуульд заасан бөгөөд сонгуулийн холимог тогтолцооны ялгаатай хувилбараас Үндсэн хуульд нийцүүлэн сонгон хуульчлах, хөгжүүлэх, нарийвчлан зохицуулах бүрэн эрх нь Улсын Их Хуралд хадгалагдана.

Тиймээс 2023 оны 6 дугаар сарын 16-ны өдөр Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж үүний дагуу 2024 оны ээлжит сонгуулийг явуулсан байна.

Улсын Их Хурлын 48 гишүүний хувь тэнцүүлэн төлөөлөх аргаар сонгох хүрээнд тус хуулийн 74 дүгээр зүйлийн 74.2.2, 74.2.3, 74.2.4 дэх заалтаар нам, эвсэлд босго тогтоож, мөн зүйлийн 74.3.2, 74.3.3, 74.3.4, 74.3.5 дахь заалтаар эдгээр босгыг давсан нам, эвсэлд суудал хуваарилахаар зохицуулсан байна.

Энэ зохицуулалт нь дараах үндэслэлээр Үндсэн хуулийг зөрчөөгүй байна.

1.Хувь тэнцүүлэн төлөөлөх аргыг хэрэглэх үед парламентад суудал авахын тулд нийт сонгогчийн саналаас тооцоолсон заавал авах саналын хувийг босго болгон тогтоодог. Босго тогтоосноор тухайн босгыг даваагүй нам, эвсэлд өгсөн санал гээгдэж, суудал хуваарилалтад нөлөөлөхгүй тул босго давсан болон даваагүй нам, эвсэл хооронд ялгаа үүсэж, тэгш сонгох эрхийг хязгаарлах үр дагавартай. Тэгш сонгох эрх нь ардчилсан ёсонд агуулагдсан иргэний тэгш байдлыг баталгаажуулдаг бөгөөд Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1

дэх хэсэгт заасан хүн бүр эрх тэгш байх зарчмын тусгай шаардлага юм. Энэ зарчим нь хүмүүст зохих үндэслэлээр ялгаатай хандахыг зөвшөөрнө.

Иймээс босго даваагүй болон босго давсан нам, эвсэлд өгсөн санал хоорондын ялгаа үүсэх нь зохих үндэслэлтэй эсэхийг шалгах замаар тэгш сонгох эрх зөрчигдсөн эсэхийг шийдвэрлэнэ. Сонгогч бүр бусад сонгогчидтой адил санал өгөх, тэр санал нь бусад саналтай адил тоологдох, улмаар бүх сонгогчийн өгсөн санал сонгуулийн дүнд адил нөлөө үзүүлэхийг тэгш сонгох эрхийг шаардана.

Тэгш сонгох эрх нь сонгогч бүрийн саналын тоологдох үнэ цэн болон амжилт олох үнэ цэн зарчмын хувьд адил байх агуулгатай. Тоологдох үнэ цэн нь сонгогч бүр адил тооны санал өгөх утгыг илэрхийлэх бол амжилт олох үнэ цэн нь сонгогчийн өгсөн санал суудалд хөрвөхөд адил нөлөөтэй байх утгатай.

Хувь тэнцүүлэн төлөөлөх аргын хувьд сонгогчийн өгсөн нийт саналын амжилт олох үнэ цэн адил байхыг шаардах ч босго тогтоосноор саналын амжилт олох үнэ цэнд ялгаа үүссэн байна. Гэвч энэхүү ялгаа нь зохих үндэслэлтэй байх бөгөөд эрх зүйн тодорхой байдалд тохирсон байх зарчимд нийцжээ.

Хууль дээдлэх ёс нь үндсэн эрхийг хуулиас гадуур хязгаарлахыг хориглох бөгөөд үндсэн эрхэд тавих хязгаарлалтыг хуульд хэлбэрийн хувьд тусгаснаар энэ зарчим хангагдахгүй. Харин түүний үндэслэл, журмыг тодорхой хуульчлах буюу эрх зүйн тодорхой байдлыг хангах шаардлагатай. Тус хуулийн 74 дүгээр зүйлийн 74.2 дахь заалтаар нам нийт саналын 4 хувь, 74.2.3 дахь заалтаар 2 намын эвсэл нийт саналын 5 хувь, 74.2.4 дэх заалтаар 3 эвсэл түүнээс дээш намын эвсэл нийт саналын 7 хувиас доошгүй санал авсан тохиолдолд суудлыг хувь тэнцүүлэн хуваарилахаар заасан нь хоёрдмол утгагүй, тодорхой байх бөгөөд үүний үр дагаврыг сонгогч нам, эвсэл, нэр дэвшигч урьдчилан таамаглаж зан үйлдээ нийцүүлэх боломжтой байна.

Тохирсон байх зарчмын дагуу үндсэн эрхэд тавих аливаа хязгаарлалт нь хууль ёсны зорилгод хүрэхэд уялдаатай, зайлшгүй, тэнцвэртэй байх шалгуурыг хангах ёстой. Хувь тэнцүүлэн төлөөлөх арга нь суудлын эзлэх хувийг янз бүрийн нам, эвсэлд өгсөн саналын эзлэх хувьтай аль болох ойртуулдаг тул бага санал авсан олон нам суудал авах, Улсын Их Хуралд олонх бүрдэхгүй болох улмаар Засгийн газрыг эмхлэн байгуулах, хууль батлах, хуулийн биелэлтийг хянан шалгах чиг үүргээ хэрэгжүүлэх чадваргүй болох эрсдэлтэй.

Энэ эрсдэлийг бууруулах үүднээс босго тогтоон, тухайн босгыг даваагүй нам, эвсэлд суудал хуваарилаагүй нь хэт олон нам суудал авахаас сэргийлэх, Улсын Их Хурал чиг үүргээ үр нөлөөтэй хэрэгжүүлэх нөхцөлийг бий болгоход чиглэсэн байна.

Түүнчлэн эвсэлд намынхаас өндөр босго тогтоосон нь намын босгын нөлөөг сулруулахгүй байх, нам хэт хуваагдахаас сэргийлэх нэмэлт зорилгод үйлчилж байна. Нам, эвсэлд тавих одоогийн босго нь саналын амжилт олох үнэ цэнийг хамгийн бага алдагдуулсан байх тул зайлшгүй байх шалгуурт нийцжээ.

Монгол Улс хувь тэнцүүлэн төлөөлөх аргыг 1990, 2011, 2015 онд хуульчлахдаа нам, эвслийн босгыг ялгаваргүйгээр 5 хувь байхаар тогтоож байжээ.

2023 онд намын босгыг 4 хувь болгон бууруулж, эвслийн босгыг өндөрсгөсөн бөгөөд бусад ардчилсан улсад намын босгыг 3-5 хувиар тогтоох нь үр дүнтэй, зохистойд тооцогддог байна. 2 намын эвсэл 5 хувийн босго тогтоосон нь өмнөх хуулиар нам, эвсэл тавьж байсантай адил байх бөгөөд 1 нам тавих одоогийн босгоос ганц хувиар илүү байна.

3 эсвэл түүнээс дээш намын эвсэл 7 хувийн босго тогтоосон нь нам тавих босгоос 3 хувиар, 2 намын эвсэл тавих босгоос 7 хувиар илүү байна. Бусад улстай харьцуулахад эвсэл тавих эдгээр босго нь хамгийн бага түвшинд байна. Босго тогтоосон зохицуулалт нь тэнцвэртэй байх шалгуурыг хангаж байна.

Тодруулбал, Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуульд 19 нам, 2 эвсэл оролцсоноос намд тавих 4 хувийн босгыг 4 нам, 2 намын эвсэл тавих 5 хувийн босгыг 1 эвсэл хангаж суудал хуваарилагдсан байна. Ийнхүү хэт олон нам, эвсэл суудал аваагүй нь нам хуваагдах намын босгын нөлөөг сулруулахаас сэргийлэх, Улсын Их Хурал чиг үүргээ үр нөлөөтэй хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Энэ нь босго даваагүй нам, эвсэлд өгсөн саналын амжилт олох үнэ цэнийг алдагдуулсан сөрөг үр дагавраас илүү чухал байна. Түүнчлэн одоогийн босго нь хэт өндөр биш тул өрсөлдөх чадвартай нам, эвсэл суудал авах боломжийг хаагаагүй нам болон эвслийн босго хооронд хол зөрүү үүсээгүй байна.

2.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74.3.2 дахь заалт нь эрх зүйн тодорхой байдалд тохирсон байх зарчмыг хангаж байна. Тус 74.3.2 дахь заалт нь босго даваагүй нам, эвслийн авсан нийт саналын хувийг босго давсан нам, эвсэлд тэнцүү хэмжээгээр хуваан тус бүрийн авсан саналын хувь дээр нэмж тооцохоор хоёрдмол утгагүй ойлгогдож байх тул үүний үр дагаврыг сонгогч нам, эвсэл, нэр дэвшигч урьдчилан таамаглаж үйл ажиллагаагаа нийцүүлэх боломжтой байна.

Иймд энэ зохицуулалт нь эрх зүйн тодорхой байдлыг хангаж, эрх бүхий этгээд үзэмжээрээ, эсвэл дур мэдэн тооцоолох эрсдэлийг бууруулжээ.

2025 онд сонгуулийн холимог тогтолцооны зэрэгцээ хувилбарыг хуульчилж нийт гишүүний 62 хувийг олон мандаттай, бүсчилсэн 13 тойргоо сонгохоор зохицуулсан байх тул олныг төлөөлөх аргын нөлөө өндөр байна. Энэ нь их санал авсан нам давуу байдал үүсгэх төдийгүй хувь тэнцүүлэн төлөөлөх сонгуулийн саналын босгын нөлөөг ихэсгэхээр байна.

Иймд босго даваагүй нам, эвсэлд өгсөн саналын хувийг босго давсанд нь тэнцүү хэмжээгээр хуваан нэмж тооцох нь бага санал авсан намд илүү ашигтай байх тул одоогийн холимог тогтолцооны олныг төлөөлөх аргын өндөр нөлөөг бууруулах, тэнцвэржүүлэхэд үйлчилж байна.

Улсын Их Хурлын 48 гишүүнийг хувь тэнцүүлэн төлөөлөх аргаар сонгохоор хуульчилсан учраас босго даваагүй нам, эвсэлд өгсөн санал дүйцэх, үлдэх суудлыг заавал хуваарилах бөгөөд ийнхүү хуваарилах 2 загвар байна.

Тухайлбал, босго даваагүй нам, эвсэлд өгсөн саналын хувийг босго давсанд нь тэнцүү хэмжээгээр хуваан нэмэх, эсвэл хувь тэнцүүлэн хуваан нэмэх загвар байна.

Хувь тэнцүүлэн хуваан нэмэх загвар нь олныг төлөөлөх аргын өндөр нөлөөг нэмэгдүүлэх, их санал авсан намын давамгайллыг хадгалах, шийдвэр гаргах түвшинд нам, нийгмийн бүлгийн оролцоог хумих, парламентын төлөөлөх чадамжийг бууруулахаар байна. Энэ 2 загварын алийг нь хэрэглэхээс үл хамааран саналын амжилт олох үнэ цэнийг ноцтой алдагдуулаагүй байх тул зайлшгүй байх шалгуур зөрчигдөөгүй гэж үзнэ.

Босго даваагүй нам, эвсэлд өгсөн саналын хувийг босго давсанд нь тэнцүү хэмжээгээр хувааж нэмэх нь хувь тэнцүүлэн хувааж нэмэх зохицуулалттай харьцуулахад их санал авсан намд ноогдох суудлын тоог бууруулахаар байна. Гэвч бага санал авсан намд хуваарилах суудлын тоог зохистойгоор нэмэгдүүлэх замаар олныг төлөөлөх болон хувь тэнцүүлэн төлөө хийх аргын нөлөөг тэнцвэржүүлэх ашиг сонирхол нь их санал авсан намд үүсэх сөрөг үр дагавраас илүү чухал юм.

Түүнчлэн их санал авсан намын анхны саналын хувиас бууруулалгүйгээр суудлыг хуваарилсан байх бөгөөд тус зохицуулалтын улмаас үүсэх суудлын зөрүү нь харьцангуй байх тул тэнцвэртэй байна.

Босго даваагүй нам, эвсэлд өгсөн саналын хувийг босго давсанд нь тэнцүү хэмжээгээр хуваан нэмэх нь сонгогчийн саналыг бусдад шилжүүлээгүй, харин үлдсэн суудлыг хуваарилахад уг саналын хувийн нөлөөг хэрэглэсэн байна.

Иймээс сонгогч өөрийн саналыг аливаа этгээдээр төлөөлүүлэхгүйгээр өөрөө биечлэн гаргах агуулгыг өөрчлөөгүй тул шууд сонгох эрхийг хөндөөгүй байна.

3.Тус хуулийн 74-ийн дүгээр зүйлийн 74.3.3, 74.3.4, 74.3.5 дахь заалтад их үлдэгдлийн зарчим, Хэйрийн аргыг ашиглан босго давсан нам, эвсэлд суудлыг хуваарилахаар зохицуулсан нь суудал хуваарилах аргыг нэг мөр болгох замаар эрх зүйн тодорхой байдлыг хангахад үйлчилж, олон улсын сайн туршлагад нийцсэн байх бөгөөд үндсэн эрхийг хязгаарласан шинжгүй байна.

4.Тус хуулийн 74 дүгээр зүйлийн 74.2.1 дэх заалтад Улсын Их Хурлын 78 гишүүнийг олныг төлөөлөх аргаар сонгох тойрогт ноогдох нийт мандатын 50 буюу түүнээс дээш хувьд нь нэр дэвшүүлсэн байх нэмэлт шаардлагыг хуульчилжээ. Гэтэл уг шаардлагыг сонгуулийн санал хураалт дууссаны дараа суудал хуваарилах үед хэрэглэхээр заасан байна.

Үүний улмаас хэдийгээр босгыг давсан ч уг шаардлагыг хангаагүй тохиолдолд тухайн нам, эвсэлд суудал хуваарилагдахгүй үлдэх төдийгүй энэ нь бусад нам, эвсэлд өгөх боломжтой байсан саналын тоог бууруулахад нөлөөлж, тэдгээр саналыг үнэгүйдүүлэх үр дагавартай байгааг тэмдэглэж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Үндсэн хуулийн цэцэд

маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг удирдлага болгон Монгол Улсын Үндсэн хуулийн нэрийн өмнөөс дүгнэлт гаргах нь:

1.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74.2.2 дахь заалтад намын тухайд нам, эвсэлд өгсөн нийт саналын 4 буюу түүнээс дээш хувийн санал авсан байх гэж, 74.2.3 дахь заалтад “хоёр нам бүхий эвслийн тухайд нам, эвсэлд өгсөн нийт саналын 5 буюу түүнээс дээш хувийн санал авсан байх,” гэж, 74.2.4 дэх заалтад “гурав буюу түүнээс дээш нам бүхий эвслийн тухайд нам, эвсэлд өгсөн нийт саналын 7 буюу түүнээс дээш хувийн санал авсан байх.” гэж, 74.3.2 дахь заалтад “энэ хуулийн 74.2-т заасан шаардлага хангасан нам, эвслийн авсан саналын хувь болон нийт нам, эвсэлд өгсөн хүчинтэй саналын хувь хоорондын зөрүүг энэ хуулийн 74.2-т заасан шаардлага хангасан нам, эвсэлд тэнцүү хэмжээгээр хуваан нам, эвсэл тус бүрийн авсан саналын хувь дээр нэмж тооцно,” гэж, 74.3.3 дахь заалтад “энэ хуулийн 74.3.2-т заасны дагуу тооцож гаргасан хувиудын нийлбэрийг 48-д хувааж, 1 суудалд ноогдох саналын тоо, хувийг тооцож гаргана,” гэж, 74.3.4 дэх заалтад “энэ хуулийн 74.3.2-т заасны дагуу тооцож гаргасан нам, эвсэл тус бүрийн авсан саналын хувийг энэ хуулийн 74.3.3-д заасны дагуу тооцож гаргасан 1 суудалд ноогдох саналын хувьд хувааж, Улсын Их Хурлын 48 суудлыг их үлдэгдлийн зарчмаар хувь тэнцүүлэн хуваарилна,” гэж, 74.3.5 дахь заалтад “энэ хуулийн 74.3.4-д заасны дагуу 1 суудалд ноогдох саналын хувьд хуваарилахдаа бутархай нарийвчлалтай гаргаж, эхний ээлжид бүхэл хэсэгт нь тэнцэх суудлыг хуваарилах. Хэрэв хуваарилагдаагүй суудал үлдвэл хамгийн их үлдэгдэлтэйгээс нь эхлэн нэг нэгээр суудлыг нам, эвсэлд нэмж хуваарилах зарчмаар бүх суудлыг хуваарилж дуусгана.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Ардчилсан ёс, шударга ёс, ... тэгш байдал ... нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” Гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ.”, Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтын “шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй, төрийн байгууллагад сонгох, ...”, сонгогдох эрхтэй, Хорин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “... Улсын Их Хурлын сонгуулийг сонгуулийн холимог тогтолцоогоор явуулна. ... дөчин найман гишүүнийг хувь тэнцүүлэн төлөөлөх аргаар сонгоно.”, мөн зүйлийн 2 дахь хэсгийн Улсын Их Хурлын гишүүнийг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж, дөрвөн жилийн хугацаагаар сонгоно.” гэж заасныг тус тус зөрчөөгүй байна.

2.Энэхүү дүгнэлтийг Улсын Их Хуралд уламжилсугай.

Даргалагч Г.Баясгалан, гишүүд Ж.Эрдэнэбулган, Д.Гангабаатар, О.Мөнхсайхан, Ц.Цолмон.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Н.Учрал: Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлттэй холбогдуулж тухайн асуудалд томилогдсон итгэмжилсэн төлөөлөгчөөс асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгье.

Үг хэлэх, асуулт асуух гишүүд байхгүй байна.

Гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 09 дүгээр дүгнэлттэй танилцлаа.

15.10 цаг

Хууль зүйн байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороо одоогоор хуралдаж байна. Тэгэхээр Хууль зүйн байнгын хороо хуралдаж дууссаны дараа дараагийн асуудал буюу Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнийг томилох тухай асуудлыг хэлэлцэнэ.

Одоо Эдийн засгийн байнгын хороо мөн хуралдаж байгаа. Тэгээд хуралдааны дараа “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Их Хурлын тогтоолын төслийг мөн хэлэлцэх дараалалтай байна.

Дараагийн асуудал дээр Үндсэн хуулийн цэцийн 10 дугаар дүгнэлтийг бас Хууль зүйн байнгын хороо хуралдаж дуусаагүй байна.

Хууль зүйн байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороо хуралдаж дуустал чуулганы хуралдааныг түр завсарлаж байна. Байнгын хороо хуралдаж дуусахаар чуулганы нэгдсэн хуралдаан үргэлжилнэ. Гишүүд танхимд бүрэн цуглахыг хүсье. Санал хураалтаар эхлэх ёстой.

Чуулганы хуралдаан түр завсарлалаа.

15.11 цаг

Мягмар гараг 30 Арванхоёрдугаар сар 2025

Төрийн ордон “Их хуралдай” танхим 17 цаг 25 минут

ҮДЭЭС ХОЙШИХ НЭГДСЭН ХУРАЛДААН

Н.Учрал: Их Хурлын нэгдсэн чуулганы хуралдаан үргэлжилнэ.

Эдийн засгийн байнгын хороо хуралдаж дууссан байна. Хууль зүйн байнгын хороо дууссан уу? Хууль зүйн байнгын хороо санал хураагаад хуралдаан өдөрлөнө. Ингээд Хууль зүйн байнгын хорооны асуудлууд чуулганы хуралдаанаар үргэлжилж хэлэлцэгдэнэ.

Эдийн засгийн байнгын хороон дээр Эдийн засгийн эрх чөлөөний хууль дээр Ардчилсан намын бүлэг 5 хоногийн завсарлага авсан тул хэлэлцэх асуудлаас хасагдсан.

Эдийн засгийн эрх чөлөөний хууль Засгийн газраас өргөн мэдүүлсэнтэй холбогдуулаад Ардчилсан намын бүлгээс бас өргөн мэдүүлэх Эдийн засгийн эрх чөлөөний хуультай нэгтгээд Их Хурлын даргын захирамжаар Ардчилсан намын

бүлэг, Монгол Ардын намын бүлгийн гишүүдийг оролцуулсан хамтарсан ажлын хэсгийг байгуулна. Ингээд чуулганы завсарлагааны хугацаанд улс төрийн бас зөвшилцөлд хүрээд энэ Эдийн засгийн эрх чөлөөний хуулийг хаврын чуулганаар өргөн мэдүүлэхээр тогтож байна. Тэгээд аль аль намын бүлгийн дарга нар, дээрээс нь ХҮН нам, Үндэсний эвсэл, Иргэний зориг ногоон намын төлөөллийг багтаасан Эдийн засгийн эрх чөлөөний хуулийн нэгдсэн ажлын хэсгийг байгуулж ажиллахаар тогтлоо.

Бүлгийн дарга нар, зөвлөлийн дарга нар Эдийн засгийн эрх чөлөөний хууль дээр ажиллах Их Хурлын гишүүдийнхээ нэрийг өгөхийг хүсэж байна. Тэгээд хэн хийхдээ гол нь биш. Гол нь энэ эдийн засгийн эрх чөлөөний суурь харилцааг зохицуулах хуулийг батлан гаргаж, зах зээлд төрийн оролцоог хумих бодлогыг хэрэгжүүлэхгүй бол төрийн анхан, дунд шатад, ялангуяа нутгийн захиргааны байгууллагуудаар нутгийн өөрөө удирдах байгууллагууд зах зээл дэх төрийн оролцоог нэмэгдүүлэх, хувийн хэвшилтэй өрсөлдөхүйц янз бүрийн бизнес сэтгэж хийдэг байдал газар авах эрсдэлтэй.

Тийм учраас Эдийн засгийн эрх чөлөөний хуулиар төр ямар ямар бизнест оролцох вэ гэдгийг хатуу хуульчлах хэрэгтэй. Мөн Эдийн засгийн эрх чөлөөний хуульдаа зах зээл дэх төрийн оролцоог хумих бодлогуудыг тухайлан тусгаж өгөх зорилготойгоор энэ хуулийг боловсруулсан.

Тэгэхээр энэ Эдийн засгийн эрх чөлөөний хууль зүгээр малгай хууль. Үүнтэй холбогдуулаад органик олон хуулиудад өөрчлөлт орох шаардлагатай. Тэгж байж энэ эдийн засгийн эрх чөлөө амилна. Тэгэхээр зах зээлд төрийн оролцоог хумих, хувийн аж ахуйн нэгжид тулгараад байгаа асуудлуудыг шийдвэрлэх, төрийн зүгээс үүсгээд байгаа хүнд суртлуудыг чөлөөлөх зорилгоор Их Хурлын даргын захирамжаар чөлөөлье санаачилгын хүрээ хүрээнд 4 чиглэлийн хүрээнд ажиллах 12 салбарын ажлын хэсгийг байгуулсан.

Тэгээд салбар болгон дээр тулгамдаад байгаа асуудлуудыг шийдвэрлэнэ. Хуульд авсан журмуудыг цуцална. Өнгөрсөн хугацаанд хуульд авсан 56 журмыг цуцалсан. Энэ чуулганы завсарлагаагаар эдгээр 12 ажлын хэсгийн ахлагч нартай хамтраад бид нар салбарууд дээр хуульд авсан журмуудыг цуцлах ажлуудыг шат дараатай хийнэ. Ингэж байж дүрэм, журмаас чөлөөлөгдөнө. Чөлөөлөх бодлого цаашдаа тасралтгүй явагдана. Ингэж төсвийн тэнцвэржүүлсэн орлого, ДНБ-ий харьцааг 30 хувь бууруулсан шийдвэрийг амилуулна. Цаашдаа ирэх жил энэ тэнцвэржүүлсэн орлого GDP-ийн харьцаа 28 хувь руу буурах ёстой. Үүнийг хэрэгжүүлэх энэ мөчлөг сөрсөн бодлогыг хэрэгжүүлэхгүй бол төсвийн бодлого алдагдана. Тийм ч учраас өнөөдөр Эдийн засгийн байнгын хороон дээр энэ үнийн өсөлтөөс иргэдээ хамгаалах тухай Засгийн газарт болон Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанканд “Чиглэл өгөх тухай” тогтоолыг Эдийн засгийн байнгын хорооны гишүүд баталж өгсөнд талархаж байна. Өнөөдөр чуулганы хуралдаанаар хэлэлцэнэ. Энэ тогтоолын хэрэгжилтэд Их Хурлын чуулганы завсарлагаагаар Тэмүүлэн гишүүнээр ахлуулсан ажлын хэсэг байгуулж, мөн нам, намын бүлгүүд, зөвлөлийн гишүүдийг нэгтгэж энэ үнийн өсөлтөөс иргэдийг хамгаалах, мөнгө хүүлэлтээс иргэдийг хамгаалах чиглэлээр Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороон дээр тодорхой асуудлуудыг шийдэж ажиллана гэдгийг хэлье.

Хууль зүйн байнгын хороо хуралдаж дууссан бол Хууль зүйн байнгын хорооны гишүүдийг танхимд урьж байна. Хууль зүйн байнгын хороон дээр хэлэлцсэн асуудлуудаар үргэлжилж хэлэлцүүлэг өрнөнө. Мөн Эрдэнэсийн сангийн орлого, зарлагатай холбогдуулсан асуудлаар санал хураалт явуулах ёстой. Төсвийн гүйцэтгэл 25 оны гүйцэтгэл, 26 оны төсвийн тухай тогтоолын төслөөр батлах шаардлагатай байна. Мөн Төрийн байгуулалтын байнгын хороо уралдаж байна уу, Хууль зүй биз дээ Сандаг-Очир дарга даргалж байгаа юм уу? Сүүлийн санал хураалт. Сүүлийн санал хураалт явагдаж байна. Эдийн засгийн байнгын хорооны дарга, гишүүдийг танхимд урья.

Хууль зүйн байнгын хорооны хуралдаан өндөрлөсөн байна. Хууль зүйн байнгын хорооны гишүүдийг танхимд урьж байна. Эхний асуудал эхлээд санал хураалтаар эхлэх үү? Хэлэлцэх асуудалдаа орёе.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнийг томилох тухай асуудлыг хэлэлцэнэ.

Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Жудгийн Баярмаа танилцуулна. Индэрт урья.

Ж.Баярмаа: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын шүүхийн тухай хуульд Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнийг Улсын Их Хурал нээлттэйгээр нэр дэвшүүлж, сонгон шалгаруулсны үндсэн дээр нэр дэвшигчийн сонсгол хийж томилохоор заасан.

Монгол Улсын шүүхийн тухай хуульд Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүний сонгон шалгаруулалтыг нээлттэй, ил тод, хараат бусаар зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг олон талын тэнцвэртэй төлөөллийн үндсэн дээр байгуулна гэж заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Өргөдлийн байнгын хорооны дарга Номинчимэг ахалж, Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Дондов, Ерөнхийлөгчийн Тамгын газрын Хуулийн бодлогын газрын дарга Мөнхболд, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Мягмар, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн захирал Амарсанаа, Монголын Хуульчдын Холбооны Ерөнхийлөгч Мөнхбат, Монголын Өмгөөлөгчдийн Холбооны Ерөнхийлөгч Данзанноров, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн Ажлын албаны Хуулийн бодлогын хэлтсийн ахлах зөвлөх Оргилболд, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн зөвлөх Номингэрэл, Шүүхийн сургалт, мэдээллийн академийн эрдэмтэн, нарийн бичгийн дарга Дөлгөөн, Шихихутаг их сургуулийн эрдэмтэн, нарийн бичгийн дарга Нармандах нарын бүрэлдэхүүнтэй байгуулсан болно.

Ажлын хэсэг Монгол Улсын Шүүхийн тухай хууль, Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах журмын дагуу сонгон шалгаруулалтын зарыг нийтэд мэдээлэх, нэр дэвших тухай хүсэлт, материал хүлээн авах, нэр дэвшигчээр бүртгэж, нийтэд мэдээлэх, илтгэгч гишүүнийг томилох, нэр дэвшигчийн баримт бичгийг Parliament.mn цахим хуудсанд байршуулах, нэр дэвшигчийн талаар мэдээлэл цуглуулах, шинжлэн судлах, нэр дэвшигч тус бүртэй ажлын хэсгийн ярилцлага зохион байгуулах, нэр дэвшигчийг тодруулан Улсын Их Хуралд санал болгох гэсэн

тодорхой үе шатын хүрээнд сонгон шалгаруулалтыг олон нийтэд нээлттэй, ил тод зохион байгуулсан.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүний сонгон шалгаруулалтын зарыг олон нийтэд нээлттэй, ил тод, хүртээмжтэй байдлаар мэдээлэн хүсэлт, материалыг 2025 оны 9 дүгээр сарын 30-ны өдрөөс 10 дугаар сарын 20-ны өдрийг хүртэл 21 хоногийн хугацаанд хүлээн авсан бөгөөд тус хугацаанд 25 хүн материалаа ирүүлсэн.

Ажлын хэсэг хүсэлт материалыг хүн тус бүрээр хэлэлцэн хууль тогтоомжид заасан шаардлага хангасан гэж үзэн тус 25 хүнийг сонгон шалгаруулалтын оролцогчоор бүртгэсэн. Сонгон шалгаруулалтад 25 нэр дэвшигч оролцсоноос 1 нэр дэвшигч өөрийн хүсэлтээр нэрээ татсан бөгөөд Монгол Улсын Шүүхийн тухай хуульд заасны дагуу санал хураалтын дүнгээр ажлын хэсгийн гишүүдийн олонхын санал авсан нэр дэвшигчийг саналын дарааллаар эрэмбэлэн сул орон тоогоор нэр дэвшүүлж, Байнгын хороонд хүргүүлэх заалтын дагуу нэр дэвшигч Хүрэлбаатарын Эрдэм-Ундрах, Чадраабалын Баянжаргал, Цэнд-Аюушийн Жавхлантөгс, Чинзоригийн Өнөржаргал нарыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшүүлэн Хууль зүйн байнгын хороонд танилцуулсан болно.

Хууль зүйн байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль, Монгол Улсын шүүхийн тухай хууль, Нийтийн сонсголын тухай хууль, Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах журамд заасны дагуу нэр дэвшигчийн сонсголыг 2025 оны 12 дугаар сарын 24-ний өдөр зохион байгуулж, сонсголын тайланг гаргасан.

Хууль зүйн байнгын хороо 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаараа нэр дэвшигчийн сонсголын тайлан болон Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшүүлэх асуудлыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 108 дугаар зүйлд заасны дагуу хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар тус асуудлыг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар, Д.Ганбат, Ж.Баярмаа, Ц.Сандаг-Очир нар нэр дэвшигчдээс асуулт асууж, хариулт авсан бол Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг, Баасанжаргал, Эрдэнэболд, Энхбаяр, Ганбат, Сандаг-Очир нар үг хэлсэн болно.

Байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Баасанжаргал нэр дэвшигчдийн талаар санал хураалтыг нууцаар явуулах горимын санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй тул Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 108 дугаар зүйл, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 77 дугаар зүйл, Хууль зүйн байнгын хорооны 2021 оны 06 дугаар тогтоолоор баталсан Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах журмын 13 дугаар зүйлийн 13.5, 13.6 дахь хэсэгт заасны дагуу нэр дэвшигч тус бүрээр санал хураалт явуулсан бөгөөд нэр дэвшигч Хүрэлбаатарын Эрдэнэ-Ундрах, Чадраабалын Баянжаргал нарыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлж, Шүүхийн

ерөнхий зөвлөлийн гишүүнээр томилуулах нь зүйтэй гэж үзсэн бол нэр дэвшигч Цэнд-Аюушийн Жавхлантөгс, Чинзоригийн Өнөржаргал нар нь Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын санал аваагүй болно.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүн нэр дэвшигчийн танилцуулга, “Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнээр томилох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл болон Байнгын хорооны санал, дүгнэлтийг гишүүд та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшүүлэх асуудлыг хэлэлцсэн талаар Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Хуралдаан даргалагч, Улсын Их Хурлын гишүүн Сандаг-Очир.

Н.Учрал: Баярмаа гишүүнд баярлалаа. Чуулганы нэгдсэн хуралдааны танхимд нэр дэвшигч Хүрэлбаатарын Эрдэм-Ундрах, Чадраабалын Баянжаргал нар хүрэлцэн ирсэн байна.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж нэр дэвшигчдээс асуулт асуух гишүүд нэрсээ өгье.

Сүхбаатарын Эрдэнэболд гишүүнээр тасаллаа. Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн асуулт асууна.

С.Эрдэнэболд: Байнгын хороонд сонсгол болон Байнгын хороон дээр бас байр сууриудаа илэрхийлсэн учраас нуршаад яах вэ. Гэхдээ Монгол Улсын шүүх засаглал бол Үндсэн хуулийн дагуу засаглалын нэг том салаа мөчир. Тэгэхээр энэ шүүх засаглалдаа парламент нь ч хүндэтгэн хүндэтгэлтэй хандан, шүүх засаглал нь ч гэсэн бусад засаглалдаа хүндэтгэлтэй хандах ёстой гэдэг утгаараа Шүүхийн ерөнхий зөвлөлөөс цаашдаа ямар нэгэн хүнийг нь сугалж аваад энд тэнд даргаар томилдог байж болохгүй гэдгийг бас Улсын Их Хуралдаа хэлмээр байгаа юм.

Өнгөрсөн жил Шүүхийн ерөнхий зөвлөл дундаас бас 1 хүнийг татаж аваад зөвлөхөөрөө томилсон ийм асуудал гарч байсан. Сая бас Цэцээс 1 гишүүнийг нь сугалж аваад өөр албан тушаалд томилж байгаа зүйл гарч байгаа. Тэгэхээр энэ яг шүүх эрх мэдлийн байгууллагаас ямар нэгэн байдлаар улс төрийн утгаараа томилгоонд хүмүүс авдаг байх ёсгүй гэсэн байр суурь байгаа. Энийг бас тэмдэглэлд буюу протоколд тусгаж хэлмээр байна. Нэг.

2 дугаарт, энэ 2 нэр дэвшигчийн зүгээс одоо бид нар яасан бэ гэхлээрээ 25, 6 хүнээс 6 хүн энэ богино жагсаалтад оруулах боломжтой байсан. Гэхдээ 4 хүн богино жагсаалтад орсон. 4-өөс 2 нь Байнгын хорооны саналаар орж ирж байгаа юм. Тэгэхээр одоо ямар асуудал үүсэж байна гэхлээрээ дахиад 2 хүний орон тоон дээр 9 гишүүний 5 нь шүүгч, 4 нь шүүгч бус, тэгэнгүүт дахиад 2 хүний орон тоон

дээр эхнээсээ ингээд үйл явц буюу процесс явна. гэсэн үг. Тэгээд энэ процесс ингээд явна.

Хэрвээ магадгүй жишээлбэл 6 хүн ч юм уу боломжийн дагуу ороод ирчихсэн бол бид энэ цагийг бас ингээд товчлох боломж байжээ гэж харагдаж байгаа. Тийм учраас Улсын Их Хурал ч гэсэн өөрсдөө энэ сонсгол зохион байгуулах ажлын хэсэг нь бас ажлаа жоохон чанаржуулж, сайжруулах ёстой юм байна гэсэн дүр зураг харагдаж байгаа юм.

Тэгээд энэ 2 хүн маш итгэл үнэмшилтэйгээр мөрийн хөтөлбөрөө танилцуулсан хүмүүс нэг нь 100 хувийн санал, нэг нь бараг 70-аад хувийн санал ингээд авч байж, Байнгын хорооноос санал авч орж ирж байгаа. Ерөнхийдөө Монгол Улсын Шүүхийн ерөнхий зөвлөлийн алсын хараа, тулгамдаж байгаа асуудал, шүүгч нарын эрхийн асуудал, ялангуяа хөдөө орон нутагт байгаа шүүхийн тэр зөөлөн дэд бүтэц, хатуу дэд бүтцийн буюу нэлээн олон шийдлүүдийг санал болгосон. Тэгээд 2 нэр дэвшигч саяын ингээд сонсголын үеэр ч тэр, Байнгын хорооны үеэр ярьсан зүйлээ бас ажил хэрэг болгоорой гэж хүсье. Дахиад замын дундаас 6 жилээ болгохгүйгээр ямар нэгэн дарга нарын томилгоо аваад явдаг эд нар байж, зүйл байж болохгүй гэдгийг хэлмээр байна.

Тэгээд 2 нэр дэвшигчдээ амжилт хүсье.

Н.Учрал: Сүхбаатар Эрдэнэболд гишүүн үг хэллээ. Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Үг хэлэх гишүүд нэрсээ өг.

Мөнхбаясгалан гишүүнээр тасаллаа. Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн үг хэлнэ. Мөнхбаясгалан гишүүн.

Л.Мөнхбаясгалан: Нэрээ татъя.

Н.Учрал: Уянгахишиг гишүүн үг хэлнэ.

Г.Уянгахишиг: Сая яах вэ ерөнхийдөө Байнгын хороон дээр болон сонсголоор хүмүүсийн байр суурь болон бас бусад сонсголын үеэр мэдэгдээгүй боловч дараагийн хүмүүсээс ирсэн мэдээллүүд сонсогдсон л доо. Тэгэхээр тэн дээр юм хэлмээр байгаа нь юу гэхээр Шүүхийн ерөнхий зөвлөл гэдэг өөрөө шүүгч нарыг томилдог, сонгон шалгаруулдаг маш чухал байр сууриа илэрхийлдэг, шударга байх, ёс зүйтэй байх гээд маш өндөр шалгуур тавигддаг ийм албан тушаал. Тэгэхээр энэ дээр яг Чадраабалын Баянжаргалтай холбоотойгоор Байнгын хороон дээр Даваагийн Цогтбаатар гишүүнд ирсэн, тэр иргэнээс ирсэн мэдээллийг сонссон. Тэгэхээр энэ дээр ер нь яах вэ өөрөө бол хариулахдаа энэ дээр ямар ч асуудал байхгүй, мэдэхгүй байна. Цагдаад гомдол ирсэн зүйл байхгүй байна гэсэн.

Гэхдээ энэ дээр маш хариуцлагатай хандаарай гэж би бас нэр дэвшигчид ч хэлмээр байна. Хэрвээ жишээлбэл бусад албан тушаалуудын хувьд гэм буруу нь тогтоогдоогүй ч гэдэг юм уу, шүүхээр маргаан явж байгаа бол, эцэслэгдээгүй бол энэ тухайн хүний ажил, хөдөлмөр эрхлэлтэд нь нөлөөлөхгүй байх гэдэг зарчим

үйлчилж болно. Гэвч Шүүхийн ерөнхий зөвлөл гэдэг өөрөө шүүгч нарт нөлөөлөх нөлөөлөлтэй учраас хэрвээ шүүхээр үнэхээр асуудал нь явж байгаа бол Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн байхад яг зарчмын хувьд нийцэхгүй гэж харж байгаа.

Тэгэхээр энэ иймэрхүү нөгөө асуудлууд байгаа нөхцөлд энийг эхлээд тодотгох ёстой байсан уу үгүй юү гэдэг ийм энийг л бас хэлчихье л гэж бодож байна л даа. Тийм.

Н.Учрал: Уянгахишиг гишүүн үг хэллээ. Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн үг хэлнэ.

С.Эрдэнэбат: Нэр дэвшигчдэд амжилт хүсье. Тэгэхдээ нэг зүйлийг бас хэлмээр байна. Байнгын хороогоор олонхын санал аваагүй нэр дэвшигч чуулганаар орж ирэхгүй гэдэг дэгтэй юм байна. Тэгэхээр энэ шүүхийн асуудал зөвхөн уг Байнгын хорооноос хамааралтай болж байгаа нь хэр зүйтэй юм бол доо? Магадгүй энэ чинь санал хураахаар хэдэн 2, 3 гишүүний наанатай цаанатай асуудлаар шийдэгдэх болов уу гэж бодож байна. Тэгэхээр бид нар өөрсдөө уг гишүүдийг сонгон шалгаруулах, томилох энэ процессынхоо юмыг бас харахгүй бол эргээд хэт явцуу хүрээнд тэр хороог л даваагүй бол орж ирэхгүй гэдэг энэ байдал нь өөрөө хэр зэрэг бусад нөгөө нэр дэвшигч Их Хурлаар томилогддог хүмүүсээс арай өөр дэгтэй юм байна гэж сая надад тийм тайлбар өгч байна.

Тийм учраас би нөгөө 2 дэвшигчийн хувьд бас нөгөө өөр хэд байдаг юм тэр хүмүүсийн хувьд Байнгын хорооны босгыг давахгүй байх тийм ноцтой шалтгаан байсан уу үгүй юу? Би зүгээр халт харж байсан нэг хүн нь өөр ажил, хуулийн судалгааны ажил гүйцэтгэнэ гэж хийгээд тэрийгээ бүрэн хийгээгүй гэдэг байдлаар хэлж байх шиг байсан. Тэгэхдээ тэр өөрөө Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнд байх шалгуурт бүрэн шууд хамааралтай асуудал уу үгүй юу гэдэг ийм асуудлыг бас би хэлмээр байна. Тийм учраас энэ манай Хууль зүйн байнгын хорооны гишүүд энэ тал дээр нэмэлт, тайлбар, мэдээлэл байвал бас өгөөч гэж хэлмээр байна.

Н.Учрал: Эрдэнэбат гишүүн үг хэллээ.

Улсын Их Хурлын гишүүд үг хэлж дууслаа.

Хууль зүйн байнгын хороо нэр дэвшигч нараас 2 нэр дэвшигчийг Байнгын хорооны олонхын саналаар дэмжсэн байна. Томилгооны сонсгол явагдсан. Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авсан. Ингээд 2 нэр дэвшигчийг л Байнгын хороо дэмжсэн гэсэн үг. Тэгэхээр цаашдаа гарсан орон тоон дээр хуулийнх нь дагуу сонсгол зохион байгуулаад дахин Байнгын хороон дээр дараагийн нэр дэвшигч нарыг оруулж ирж дэмжих ийм процесс явна.

Өнөөдрийн хувьд чөлөөлөгдөх гишүүд хуулийн хугацаа дууссан учраас чөлөөлөгдөж байна. Гэхдээ 2 нэр дэвшигч л өнөөдөр Байнгын хороо дэмжсэн учраас чуулганаар хэлэлцэгдэнэ гэсэн үг.

Одоо Хууль зүйн байнгын хорооны саналаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлтгэе.

Баасанжаргал гишүүн горимын санал гаргана. Баасанжаргал гишүүн.

Х.Баасанжаргал: Бид нар Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүний томилгоо буюу энэ нэр дэвшээд орж ирж байгаа хүмүүс дээр хувь хүнийх нь хувьд бид нар сонголт хийх гэж байгаа нэр дэвшигчийн хувьд. Санал хураалт илээр явуулах ийм зарчимтай байдаг юм байна. Тэгээд манай Байнгын хороо бас илээр явуулах уу, нууцаар явуулах уу гээд санал хураалт яваад илээр энэ санал хураалтыг явсан.

Би бас чуулган дээр энэ санал хураалтыг нууцаар бөгөөд цахимаар явуулах ийм горимын санал гаргаж байна. Хуралдаанд оролцогч гишүүд бас энийг олонхоороо шийдвэрлэх байх.

Би яагаад нууц байх ёстой вэ гэдэг байр сууриа хамгаалаад 2 өгүүлбэр хэлчихье.

1 дүгээрт, нууц санал өгснөөрөө санал өгч байгаа хүмүүс нөлөөнд автахаас хамгаалагддаг, сэргийлэгддэг. Тэгэхээр хамгийн чухал ийм албан тушаалын томилгооны нэг нь манай Улсын Их Хурлын томилгооны нэг нь Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүд байдаг.

2 дугаарт, шударга байдлыг хангана.

3 дугаарт, чөлөөтэй бид нар сонголтоо хийх боломжтой болох юм. Тийм учраас Их Хурлын гишүүдийг энэ санал хураалтыг нууц бөгөөд цахимаар хийхийг дэмжиж саналаа өгөөч гэдэг ийм горимын санал гаргаж байна.

Н.Учрал: Их Хурлын гишүүн нууцаар санал хураах гэсэн санал, горимын санал гаргасан. Баасанжаргал гишүүний саналаар санал хураалтыг явуулъя.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнийг томилох санал хураалтыг нууцаар явуулахыг, нууцаар, тэгээд цахимаар шүү дээ мэдээж. Нууцаар явуулах уу гэсэн саналыг дэмжих үү гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна мөн биз? Нууцаар, цахимаар явуулъя гэснийг дэмжих үү гэсэн санал хураалтыг явуулъя. Санал хураалт.

29 гишүүн дэмжиж, горимын санал дэмжигдсэнгүй.

Одоо Хууль зүйн байнгын хорооны саналаар санал хураалтыг явуулна.

1.Хүрэлбаатарын Эрдэм-Ундрахыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана. Гишүүд анхааралтай байя. Дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт.

58 гишүүн дэмжиж, 71.6 хувиар санал дэмжигдлээ.

2.Чадраабалын Баянжаргалыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана. Санал хураалт.

54 гишүүн дэмжиж, 66.7 хувиар санал дэмжигдлээ.

Хууль зүйн байнгын хорооны саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул “Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнээр томилох, чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцлоо.

Бейсен гишүүнийг дэмжсэнээр протоколд үлдээе.

Улсын Их Хурлын тогтоолын төслийг та бүхэнд танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын тогтоол “Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнээр томилох, чөлөөлөх тухай”

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1, 76.2, 76.5 дахь хэсэг 83 дугаар зүйлийн 83.1.1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 108 дугаар зүйлийн 108.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:

1.Хүрэлбаатарын Эрдэм-Ундрах, Чадраабалын Баянжаргал нарыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнээр тус тус томилсугай.

2.Бүрэн эрхийн хугацаа нь дуусгавар болсон тул Навагчамбын Баасанжав, Нямсүрэнгийн Мөнгөнцэцэг, Ренчиндоржийн Онончимэг, Дорждамбын Зүмбэрэллхам нарыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнээс чөлөөлсөнгүй.

3.Энэ тогтоолыг 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

“Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнээр томилох, чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүд байна уу?

Сайнзориг гишүүн санал хэлнэ.

П.Сайнзориг: Баярлалаа. Тэгээд энэ Үндсэн хуулийн зарчим нь Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүний 10 гишүүн буюу шүүгч нараас 50 хувь, шүүгч бус хүмүүсээс 50 хувийг бүрдүүлэхдээ бүрдүүлэх ёстой байгаа. Өнөөдрийн ийм байдлаар томилгооны дараах үр дүнгээр үндсэндээ 5, 3-ын харьцаатай буюу 8 гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэх бололцоотой байна. Үлдэж байгаа энэ 2 сонгон шалгаруулалтыг шинээр яаралтай зарлаад хаврын чуулган эхлэхэд яаралтай томилох ёстой шүү гэдэг зүйлийг 1 дүгээрт хэлмээр байгаа юм.

2 дугаарт бас Байнгын хорооны түвшинд хэлж байсан. Энэ өмнөх хүмүүсийн ажлыг сонсдог байхгүй бол тэр хүмүүс ер нь юу хийж бүтээхээд юу үлдээхээд явсан бэ гэдэг зүйлийг мэдэхгүйгээр ингээд чөлөөлөөд явуулчихдаг ийм зүйлүүд байна. Дараагийнх нь томилоод явуулчихдаг. Тэгэхдээ магадгүй яг үүнтэй зэрэгцүүлээд сонсох биш ажлаа өгсөн хүмүүсийг юу гэдэг юм дараагийн Байнгын хорооны, дараагийн чуулганы хугацаанд гэдэг юм уу яг энэ тодорхой хугацаа

заагаад бас ийм зүйлийг нь сонсдог энэ жишиг рүү явах ёстой шүү гэдэг зүйлийг энэ дээр хэлмээр байна.

Тэгээд томилогдож байгаа хүмүүст амжилт хүсье.

Н.Учрал: Шүүхийн ерөнхий зөвлөлийн “Шүүгч бус гишүүнээр томилох, чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнээр Их Хурлын гишүүдийн олонхын саналаар томилогдсон Хүрэлбаатарын Эрдэм-Ундрах, Чадраабалын Баянжаргал нарт ажлын амжилт хүсье.

17.59 цаг

“Монгол Улсын Эрдэнэсийн сангийн үндсэн сангийн орлого, гүйлгээ сангийн орлого, зарлагын 2025 оны гүйцэтгэл, 2026 оны төсвийн тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үргэлжлүүлэн хэлэлцэнэ.

Улсын Их Хурлын гишүүд Эрдэнэсийн сангийн орлого, зарлагын тайлан, шийдвэрийн төсөлтэй холбогдуулж асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууссан.

Одоо Байнгын хорооны саналаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлтгэе.

Байнгын хорооны саналаар “Монгол Улсын Эрдэнэсийн сангийн орлого, зарлагын 2025 оны гүйцэтгэл, 2026 оны төсвийн тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томьёолоор санал хураана. Санал хураалт.

48 гишүүн дэмжиж, 59.3 хувиар санал дэмжигдэж дэмжигдлээ.

Тогтоолын төслийг баталлаа. Улсын Их Хурлын гишүүд ажлын хэсэгт талархал илэрхийлье.

18.00 цаг

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 10 дугаар дүгнэлт /Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйл Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай/

Дараагийн асуудалд оръё. Хууль зүйн байнгын хороо хуралдаж Үндсэн хуулийн цэцийн 10 дугаар дүгнэлттэй холбогдуулж 10 дугаар дүгнэлтийг Их Хурлаар хэлэлцэх асуудлыг оруулж ирсэн байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 10 дугаар дүгнэлтийг хэлэлцье.

Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцийн гишүүн Одонхүүгийн Мөнхсайхан танилцуулна. Мөнхсайхан гишүүнийг индэрт урья.

О.Мөнхсайхан: Монгол Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Та бүхэнд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 10 дугаар дүгнэлтийг танилцуулж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн дарга Г.Баясгалан даргалагч, Үндсэн хуулийн цэцийн гишүүн Д.Гангабаатар, Л.Өлзийсайхан, илтгэгч О.Мөнхсайхан, Р.Батрагчаа нарын бүрэлдэхүүнтэй хуралдааны Нарийн бичгийн даргаар Б.Баяржаргалыг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд 2025 оны 11 дүгээр сарын 24, 25-ны өдөр нээлттэй хийв.

Дунд суудлын хуралдаанд мэдээлэл гаргагч иргэн Ж.Баттуул, Л.Галбаатар, Т.Сумъяабазар, Д.Чанцалдулам, Э.Энэрэл, Б.Анхзаяа, Э.Хүрэлбаатар, С.Номынбаясгалан, өмгөөлөгч Д.Оросоо З.Тамир болон Монгол Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр, мөн шинжээчээр Хууль зүйн ухааны доктор, профессор Д.Солонгоо, Хууль зүйн ухааны доктор, дэд профессор Б.Тэмүүлэн, сэтгүүлч З.Борилмаа нар оролцов.

Энэхүү хуралдаанаар Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлд Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан, илт худал мэдээллийг олон нийтэд тараасан бол ял шийтгэхээр заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан хэлэлцэв.

Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 10 дугаар дүгнэлт нь нийт 37 хуудас, үндэслэл хэсэг нь дангаараа 23 хуудас учраас дүгнэлтийн үндэслэл хэсгийг товчилж, тогтоох хэсгийг бүхэлд нь уншиж сонсгоё.

Үндэслэл.

1.Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 16, 17 дахь заалтад үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө нь ардчилсан нийгмийн суурь үнэт зүйл болохыг өргөн агуулгаар баталгаажуулжээ. Энэхүү эрх чөлөө нь итгэл үнэмшил, үзэл бодолтой байх, түүнийгээ үг хэлэх, хэвлэн нийтлэх болон бусад хэлбэрээр чөлөөтэй илэрхийлэх, мэдээлэл хайх, хүлээн авах, түгээх, төрийн байгууллагад байгаа мэдээллийг авах зэрэг харилцан хамаарал бүхий цогц эрхийг өөртөө багтааж байна.

Энэхүү эрх чөлөө нь оюуны эрх чөлөө, нээлттэй, ил тод байдал, олон ургалч үзэл, иргэдийн оролцооны үндэс болж, ардчиллыг бодитой хэрэгжүүлэх, үнэнийг танин мэдэх, хувь хүний чөлөөт хөгжил, бие даасан байдлыг баталгаажуулахад ач холбогдолтой юм. Хэвлэн нийтлэх эрх чөлөө нь ардчилсан нийгэмд онцгой үүрэг гүйцэтгэдэг учраас Үндсэн хууль түүнийг тусгайлан нэрлэж, иргэд төдийгүй сэтгүүлч, хэвлэл мэдээллийн хэрэгсэлд баталгаатай эдлүүлэх агуулгаар тусгагдсан.

Төрийн эрх мэдэл ард түмнээс уг сурвалжтай тул төрийн байгууллага, албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаа нь нийтийн хяналтад байх ёстой бөгөөд иргэд

энэ төрлийн мэдээлэл хүлээн авч, үзэл бодлоо төлөвшүүлэхэд хамгийн үр нөлөөтэй хэрэгслийн нэг нь хэвлэл мэдээлэл байдаг.

Цензурээс ангид хэвлэл, мэдээллийн хэрэгсэл нь иргэн бүр улс төрийн чөлөөт хэлэлцүүлэгт болон төрийн үйл хэрэгт оролцох, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх болон бусад эрхээ баталгаатай илэрхийлэхэд, эдлэхэд ач холбогдолтой. Итгэл үнэмшил, үзэл бодолтой байх эрх чөлөө нь хувь хүний дотоод мөн чанарыг хамгаалдаг туйлын эрх тул түүнийг ямар ч тохиолдолд хязгаарлаж болохгүй. Харин итгэл үнэмшил, үзэл бодлыг илэрхийлэх нь гадагш чиглэсэн нийтэд хамаатай тул Үндсэн хуульд заасан шаардлагын дагуу ийнхүү илэрхийлэх эрх чөлөөнд хязгаарлалт тогтоох боломжтой.

Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалтын халдашгүй чөлөөтэй байх эрхийн хүрээнд хүний нэр, төр алдар хүндийг хамгаална. Хүний нэр төр бол хүн болж төрсөн хэн бүхэнд угаас заяасан адил үнэ цэн бөгөөд туйлын эрхэд тооцогдоно. Алдар хүнд бол хувь хүний нийгэмд эзлэх байр суурийг илэрхийлэх гадаад үнэлэмж бөгөөд түүнд хууль бусаар халдахыг хориглоно.

Иймд Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйл нь илт худал мэдээлэл тараахыг хориглох замаар хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд хууль бусаар халдахаас хамгаалахад чиглэсэн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөнд тогтоосон хязгаарлалт мөн байна.

2.Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөний хязгаарлалт нь үндсэн эрхийн хязгаарлалтад тавих нийтлэг шаардлага болон тухайн эрх чөлөөний мөн чанараас үүдэн гарсан тусгай шаардлагыг давхар хангах ёстой. Эдгээр шаардлагын аль нэгийг хангаагүй нь үндсэн эрхийг зөрчсөн гэх үндэслэл болно.

Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйл нь эрх зүйн тодорхой байдал, тохирсон байх зарчим зэрэг нийтлэг шаардлагыг хангаагүй байна. Тус зохицуулалт нь үндсэн эрхийг гагцхүү хуулиар хязгаарлах шалгуурыг хэлбэрийн хувьд хангасан байх боловч эрх зүйн тодорхой байдалд нийцээгүй, улмаар уг гэмт хэргийн хүрээг үндэслэлгүйгээр өргөжүүлж, олон утгаар хэрэглэх нөхцөлийг бүрдүүлжээ.

Учир нь нэгд тус зүйлийн гарчиг болон агуулгад ялгаатай нэр томьёо хэрэглэж ойлголтын зөрүү үүсгэсэн байна. Мөн хүний нэр төр болон алдар хүнд, худал мэдээлэл болон илт худал мэдээлэл гэх төстэй нэр томьёог хольж хэрэглэсэн боловч тэдгээрийг тодорхойлж ялгаагүй байна.

Хоёрт, хууль тогтоогч уг гэмт хэргийн объектив талыг илт худал мэдээллийг олон нийтэд тараасан гэж тодорхойлсон боловч субъектив талыг нь тодорхой заагаагүй бүрхэгдүүлсэн байна. Үүний улмаас тухайн мэдээлэл нь илт худал боловч хүний нэр төр, алдар хүндэд бодит хохирол учруулаагүй, түүнчлэн мэдээллийг хохирол учруулах зорилгогүйгээр тараасан, эсвэл дамжуулсан ялимгүй тохиолдлыг ч хүний нэр төр, алдар хүндэд халдсан гэж үзэж гэмт хэрэгт тооцохоор байна.

Гуравт, олон нийтэд тараасан гэж үзэх шалгуур хүрээ тодорхойгүйгээс нийгмийн сүлжээнд нийтэлсэн мэдээллийг цөөн хүн дэмжих, эс дэмжих, тэмдэг

дарсан, эсвэл хязгаарлагдмал хүрээнд хуваалцсан үйлдэлд ч эрүүгийн хариуцлага хүлээлгэх боломжтой болжээ.

Дөрөвт, уг гэмт хэргийн хохирогчид тооцогдох этгээдийн хүрээг хэт өргөжүүлсэн байна. Тодруулбал, төрийн байгууллага, албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагааг шүүмжилснийг хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан хэмээн ял оногдуулсан тохиолдол гарсан байна.

Тавд, эрх зүйн тодорхой байдлыг хангаагүйгээс мөрдөгч, прокурор, шүүгч уг зохицуулалтыг үзэмжээрээ, эсвэл дур мэдэн хэрэглэх, хэрэгжүүлэх, урвуулан ашиглах эрсдэл үүсгэсэн байна.

Үндсэн эрхийн хязгаарлалт нь хууль ёсны зорилгод хүрэхэд уялдаатай, зайлшгүй, тэнцвэртэй байх гэсэн шалгуурыг хангахыг тохирсон байх зарчим шаардана. Энэ дагуу шалгахад дараах үндэслэл тогтоогдож байна.

Нэгд, алдар хүндийг хамгаалах нь Үндсэн хуульд заасны дагуу үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлаж болох хууль ёсны зорилго мөн. Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйл нь хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараах үйлдлийг зогсоох боломжтой байх тул эдгээр эрх ашиг сонирхлыг хамгаалахад чиглэсэн уялдаатай байна.

Түүнчлэн хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд илт худал мэдээлэл тарааж халдсан үйлдлийг гэмт хэрэгт тооцсон байна. Энэ ойлголт нь хуулийн этгээдийн эдийн засаг, аж ахуйн шинжтэй хууль ёсны ашиг сонирхолд илүү хамааралтай тул иргэний эрх зүйн хамгаалалтад түлхүү хэрэглэгдэж ирсэн бөгөөд энэ хүрээнд үр нөлөөтэй хамгаалагдах боломжтой байна.

Иймд хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүнд нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг Эрүүгийн хуулиар хязгаарлах үндэслэл болохуйц зорилго болохооргүй байна.

Хоёрт, маргаан бүхий зохицуулалт нь хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндийг хамгаалахад зайлшгүй арга хэмжээ биш байна. Учир нь худал мэдээлэл тараах үйлдлийг гэмт хэрэгт тооцож ял шийтгэх төдийгүй эрүүгийн хэрэг үүсгэж, баривчлах, цагдан хорих, үзлэг, нэгжлэг хийх, мөрдөн шалгах, нууц ажиллагаа явуулах зэргээр үндсэн эрхэд илүү ихээр халдах боломжтой байна. Харин Иргэний хуулийн зохицуулалт нь мэдээллийн үнэн, зөвийг хариуцах, няцаалт хийх, уучлалт гуйх, гэм хорыг арилгах зэрэг илүү хөнгөн аргаар хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндийг адилхан үр нөлөөтэй хамгаалж, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөө болон бусад үндсэн эрхэд илүү бага хэмжээгээр халдахаар байна.

Түүнчлэн Монгол Улсад хэрэгжиж буй сэтгүүлчийн ёс зүйн зөрчил болон мэргэжлийн алдааг хянан шийдвэрлэж, сахилгын шийтгэл хүлээлгэх, өөрийн зохицуулалтын механизм нь хэвлэн нийтлэх эрх чөлөөнд илүү бага халдсан шүүхийн бус арга замаар алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндийг хамгаалах боломжтой байна.

Гуравт, Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйл нь хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд хохирол учруулсан илт худал мэдээллээс гадна ийм хохирол учруулаагүй үзэл бодлын бусад илэрхийллийг хязгаарлаж, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх болон хэвлэн нийтлэх эрх чөлөөний хэрэгжилтэд хэт сөрөг нөлөө үүсгэсэн байх тул тэнцвэртэй байх шалгуурыг хангаагүй байна.

Тодруулбал, авлига, албан тушаалын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчил зэрэг нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлсний төлөө эрүүгийн хэрэгт шалгагдах, баривчлагдах, цагдан хоригдох зэргээр үндсэн эрхээ хязгаарлуулах, цаг хугацаа алдах, зардал гаргах, улмаар ял шийтгүүлэх боломжтой байна. Эрүүгийн хэрэгт буруутгаж буй хэн ч ийм нөхцөл байдалтай нүүр тулах боловч худал мэдээлэл тараах гэмт хэргийн хувьд иргэд болон хэвлэл, мэдээллийн хэрэгсэл нь үүнээс эмээж болгоомжлолд автах, улмаар нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар эрэн сурвалжлах, мэдээлэх, шүүмжлэхээс татгалзах буюу өөрийгөө цензурдэх бодит эрсдэл үүсгэж, иргэдийн мэдээлэл хүлээн авах эрхийн хэрэгжилтэд саад учруулж байна. Түүнчлэн уг зохицуулалт нь нийтийн ашиг сонирхолтой холбоотой асуудлаар шүүмж илэрхийлсний төлөө иргэд болон хэвлэл мэдээллийн байгууллага ажилтны эсрэг гомдол гаргаж, эрүүгийн хэрэгт шалгуулах замаар ардчилсан нийгэм дэх олон талт шүүмжлэлт дуу хоолой, чөлөөт хэлэлцүүлгийг намжаахад урвуулан ашиглагдах эрсдэлийг бий болгож байна.

3.Хүний алдар хүндийг хамгаалах зорилгоор үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлах хуулийн зохицуулалт нь эдгээр үндсэн эрх хоорондын тэнцвэрийг хангах, Эрүүгийн хуулиар хязгаарлах тохиолдолд түүний хүрээг ноцтой түвшинд явцууруулан тодорхойлох болон нэмэлт эрхийн шалгуур зэрэг тусгай шаардлагыг хангах ёстой.

Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлд эдгээр тусгай шаардлагыг хангаагүй байна. Тус зохицуулалт нь хүний алдар хүнд халдашгүй байх эрх болон үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө хоорондын тэнцвэрийг хангаагүй байна. Учир нь:

Нэгд, нийтийн ашиг сонирхолтой холбоотой асуудлаар үзэл бодлоо илэрхийлснийг бусад төрлийн илэрхийллээс илүү хамгаалах зохицуулалтыг хуульчлаагүй байна.

Хоёрт, төрийн өндөр албан тушаалтан зэрэг нийтийн зүтгэлтэн өөрийнхөө эсрэг шүүмжийг иргэнээс илүү хүлцэн тэвчих эрх зүйн зохицуулалтыг бий болгоогүй байна.

Гуравт, үйл баримтын шинжтэй мэдээлэл болон үнэлэлт, дүгнэлтийг ялгаж зохицуулаагүйгээс үйл баримтын шинжтэй мэдээллийг үндэслэн илэрхийлсэн үнэлэлт, дүгнэлт, үзэл бодолд эрүүгийн хариуцлага хүлээлгэх эрсдэлтэй байна.

Дөрөвт, мэргэжлийн ёс зүйтэй сэтгүүл зүйг тусгайлан хамгаалаагүй байх тул нийтийн ашиг сонирхолтой холбоотой үйл баримтыг үнэнч шударгаар мэдээлэх явцад гарсан мэргэжлийн алдаанд ял шийтгэх боломжтой байна.

Эрүүгийн хуулийн зохицуулалт нь хууль бус үйлдэлд хариуцлага хүлээлгэх хамгийн хатуу эцсийн арга хэрэгсэл учраас хүний алдар хүндийг хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалт, иргэний хууль тогтоомж зэрэг бусад арга хэрэгслээр хамгаалах боломжгүй онцгой тохиолдолд л зөвтгөгдөнө.

Тодруулбал, хүний алдар хүндэд бодитой хохирол учруулсан ноцтой үйлдлийн объектив, субъектив талын шинжийг нарийвчлан зааж, гэмт хэрэгт тооцох боломжтой бөгөөд түүнд оногдуулах ял нь тухайн гэмт хэргийн шинж чанар, хэр хэмжээнд тохирсон байхыг шаардана. Хэт өндөр хэмжээгээр торгох, эсвэл хорих ял зэрэг хүнд ялаар шийтгэх нь энэ шаардлагыг хангахгүй. Эрүүгийн хуулиар зохицуулах тохиолдолд түүний хүрээг ноцтой түвшинд явцууруулан тодорхойлох төдийгүй уг гэмт хэргийг хянан шийдвэрлэх явцад үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг дур мэдэн хязгаарлахгүй байх, урвуулан ашиглахгүй байх процессын эрх зүйн баталгааг бүрдүүлэх шаардлагатай.

Тухайлбал, гэмт хэргийг хянан шийдвэрлэх явцад үндсэн эрхийг хязгаарлах асуудлыг гагцхүү хуулиар нарийвчлан зохицуулах, эдгээр зохицуулалт тохирсон байх, шүүхийн үр нөлөөтэй хяналтад байх зэрэг зарчимд бүрнээ нийцэх ёстой.

Гэтэл Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйл нь хүний алдар хүндэд бодит хохирол учруулсан байхыг шаардаагүй төдийгүй алдар хүндийг гутаасан үйл баримтын шинжтэй мэдээллийг худал гэдгийг нь мэдсээр байж санаатай тараасан байх зэрэг шалгуурыг тусгаагүй байх тул ийм хохирол учруулаагүй, ноцтой бус буюу ялимгүй үйлдэлд эрүүгийн хариуцлага хүлээлгэх боломжтой байна.

Харин худал мэдээлэл тараах гэмт хэрэгт хорих ял шийтгэхээс татгалзаж торгох ялын хэмжээг бууруулсан нь тохирсон арга хэмжээ болжээ. Нэмэлт эрхийн шалгуураар шалгахад маргаан бүхий зохицуулалт нь 2 үндсэн эрхийг хязгаарлах үр дагавартай байна.

Тодруулбал, хүний нэр төр, алдар хүндийг хамгаалах зорилгоор үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлахын зэрэгцээ зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэх болон ийм төрлийн хязгаарлалт тогтоох, таслан сэргийлэх арга хэмжээ авах боломжтой байна.

Зорчих эрхийг хязгаарлах нь иргэд болон сэтгүүлч, хэвлэл мэдээллийн бусад ажилтан нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах, түгээх эрх болон хэвлэн нийтлэх эрх чөлөөгөө эдлэхэд саад учруулах эрсдэлтэй байна.

4.Дээрхийг бүхэлд нь дүгнэж үзвэл маргаан бүхий зохицуулалт нь үндсэн эрхийн хязгаарлалтад тавих нийтлэг болон тусгай шаардлагыг хангаагүй байна.

Иймд Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйл нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан эрх чөлөөний болон хууль дээдлэх зарчмыг, Арван зургадугаар зүйлийн 16.17 дахь заалтаар хамгаалсан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөө, мэдээлэл хайх, хүлээн авах, түгээх эрхийг тус тус зөрчиж улмаар Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн Үндсэн хуульд бүрнээ нийцсэн байх зарчмыг алдагдуулсан байна.

5.Худал мэдээлэл тараахыг гэмт хэрэгт тооцсон нь үзэл бодол, итгэл үнэмшил бус харин түүний илэрхийлэлд тавьсан хязгаарлалт байх тул Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 16 дахь заалтын итгэл үнэмшилтэй байх эрх чөлөөг хөндөөгүй байна.

6.Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлээр хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараахыг хориглосон нь эдгээр эрх, ашиг сонирхлыг хамгаалах хууль зүйн баталгааг бүрдүүлэхэд үйлчилж байх тул Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийг зөрчсөн гэж үзэх үндэслэлгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг удирдлага болгон Монгол Улсын Үндсэн хуулийн нэрийн өмнөөс дүгнэлт гаргах нь:

Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлд Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараасан бол 451 нэгжээс 1300 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсвэл 240 цагаас 720 цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсвэл 1 сараас 3 сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн эрх чөлөө, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн, Арван зургадугаар зүйлийн 16 дахь заалтын үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөтэй, мөн зүйлийн 17 дахь заалтын төр, түүний байгууллагаас хууль ёсоор хамгаалбал, тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн Үндсэн хуульд хууль бүрнээ нийцсэн байвал зохино гэж заасныг тус тус зөрчсөн байна.

2.Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйл нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 16 дахь заалтын итгэл үнэмшилтэй байх эрх чөлөөтэй, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна гэж заасныг зөрчөөгүй байна.

3.Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлд хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараасан бол 450 нэгжээс 1300 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсвэл 240 цагаас 720 цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсвэл 1 сараас 3 сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ гэж заасныг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй.

4.Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хэлэлцэж хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

Даргалагч Г.Баясгалан, гишүүд Д.Гангабаатар, Л.Өлзийсайхан, О.Мөнхсайхан, Р.Батрагчаа.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Н.Учрал: Цэцийн дүгнэлтийн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн танилцуулна. Индэрт урья.

Х.Баасанжаргал: Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 10 дугаар дүгнэлтийг хэлэлцсэн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг танилцуулъя. Гэхдээ би хувь гишүүнийхээ хувьд эсрэг саналтай байсан шүү.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйл Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 10 дугаар дүгнэлтийг 2025 оны 12 дугаар сарын 24-ний өдөр Улсын Их Хуралд ирүүлснийг Хууль зүйн байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 84 дүгээр зүйлд заасан журмын дагуу 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаар хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанд Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн талаар танилцуулсан болно.

Хууль зүйн байнгын хорооны хуралдаанаар Үндсэн хуулийн цэцийн 10 дугаар дүгнэлтийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг, Уянгахишиг, Баярмаа, Эрдэнэболд нар асуулт асууж, хариулт авсан.

Эрүүгийн хуулийн 13 дугаар зүйлийн 13.14 дүгээр зүйлд хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараасан бол 450 нэгжээс 1300 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл 240 цагаас 720 цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл 1 сараас 3 сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн эрх чөлөө, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн, Арван зургадугаар зүйлийн 16 дахь заалтын үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөтэй, мөн зүйлийн 17 дахь заалтын төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн Үндсэн хуульд хууль бүрнээ нийцсэн байвал зохино гэж заасныг тус тус зөрчсөн байна гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 10 дугаар дүгнэлтийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.2.2 дахь заалтын дагуу Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн гэсэн зүйл, хэсэг, заалт бүрээр санал хураалт явуулахад Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх хүлээн зөвшөөрөөгүй болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 10 дугаар дүгнэлтийг хэлэлцсэн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Н.Учрал: Баасанжаргал гишүүнд баярлалаа.

Хууль зүйн байнгын хороо дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэсэн шийдвэрийг гаргасан байна. Үндсэн хуулиар үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх бол хүний төр, хууль бий болохоос өмнө хүнд байдаг үндсэн эрх. Тийм ч учраас үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх, эрх чөлөөг Үндсэн хууль, НҮБ-ын Хүний эрхийн түгээмэл тунхаглал зэрэг баримт бичгүүдэд хүлээн зөвшөөрч хамгаалж өгдөг. Тэгэхдээ нэг ялгаа бий. Үг хэлэх бол мэдээж хязгааргүй биш. Бусдын нэр төр, аюулгүй байдал, үндэсний аюулгүй байдал, хүчирхийлэлд уриалах зэрэгтэй зөрчилдөх юм бол хуульд заасан хүрээнд хязгаарлаж болдог. Гэхдээ өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулиудаар алдар хүнд гэж юуг ойлгох, илтэд хууль бус мэдээлэл гэж юуг ойлгохыг хүрээ хязгаарыг тодорхойлж өгөөгүйгээсээ болж үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх, эрх чөлөөнд халдаж болзошгүй. Тийм ч учраас Үндсэн хуулийн цэц тайлбар гаргасан байна.

Тайлбарт нийцүүлээд энэ эрх, эрх чөлөөг илүү баталгаажуулж өгөх хэрэгтэй. Тэгэхээр алдар нэрийг бид нар хуулиар хамгаалж хамгаална. Гэхдээ энэ агуулга доор үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх энэ эрх, эрх чөлөөнд бүдүүлгээр халдаж болохгүй. Тийм учраас 92 оны шинэ Үндсэн хуулийн батлагдсанаас хойш хугацаанд Үндсэн хуулийн цэц энэ заалттай холбоотой хууль зүйн тайлбар хийсэн байна.

Энэ тайлбарт үндэслээд Их Хурлын гишүүд цаашдаа хуулийн төслийг нийцүүлээд зохистой хэрэглэх тал руу нь анхаарч олж хараасай гэж хүсэж байна. Тийм учраас Их Хурлын даргын зүгээс чөлөөлөе гэдэг санаачилгыг дэвшүүлсэн. Хэвлэлийн эрх чөлөө, үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх, эрх чөлөөг Их Хурлын гишүүний хувиар хамгаалах байр суурьтай байгаа гэдгийг хэлье. Би үгээ хэллээ.

Одоо Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж, асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгье.

Баасанжаргал гишүүн. Тэмүүжин гишүүнээр тасаллаа. Ирцээр нэрсийн дараалалд оруулъя. Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн асуулт асууна.

Л.Мөнхбаясгалан: Би 28 жил сэтгүүлчээр ажилласан хүн. Миний мэдэхээр 1992 онд шинэ Үндсэн хууль баталснаас хойш Үндсэн хуулийн цэц анх удаа хүний үндсэн эрхээр тайлбар гаргаж байгаа нь энэ. Цэцийн дүгнэлтэд Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйл нь хүний үг хэлэх эрх чөлөө, хэвлэн нийтлэх эрх чөлөө, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, оюун санааны эрх чөлөө, нөгөө талд нь иргэний мэдэх эрх чөлөөний эсрэг үйлчилж байгаа ийм заалт болно оо гэж дүгнэлт гарсан байна.

Эрүүгийн хуулийн 13.14 нь бас хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн 3 дугаар зүйл буюу төрөөс олон нийтийн мэдээлэл, мэдээллийн агуулгад хяналт цэнзур тогтоохгүй, Эрүүгийн хуулийн нэгийн 4.4-д заасан хүний үзэл бодол, итгэл үнэмшлийн төлөө эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй гэсэн заалтуудтай зөрчилдөж байгаа юм.

Тэгээд Үндсэн хуулийн цэцийн дараагийн үгийг би бүүр уншиж өгье гэж бодож байна. Ардчилсан нийгэм дэх олон талт шүүмжлэлт дуу хоолой, чөлөөт хэлэлцүүлгийг намжаахад урвуулан ашиглах нөхцөл бий болжээ гэж, авлига, албан тушаалын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчлийг хөндсөн асуудлаар мэдээ, мэдээлэл бэлтгэх, эрэн сурвалжлах сэтгүүл зүйн бүтээл туурвих, нөгөө талд нь ард түмний эрх мэдэл энэ хэрээр зөрчигдөж байгаа ийм дүгнэлт гаргасан байна.

Энэ бол үнэхээр гайхамшигтай дүгнэлт байна. Хүний үндсэн эрхийн анх удаа тайлбарласан хууль зүйн тайлбар байна л даа. Тэгээд хүний нэр хүнд, алдар хүнд, нэр төрийг гутаан доромжилж болохгүй гэдэг үнэн. Болохгүй. Энэ хүний үндсэн эрх. Гэхдээ хүний үндсэн эрхэд хязгаарлалт тавьдаг. Энэ хязгаарлалт нь нийтлэг шаардлага, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөний хязгаарлалтад тавих тусгай шаардлагыг хангаагүй байна гэж үзсэн байгаа юм.

Тэгэхээр Эрүүгийн хуулийн энэ 13.14 дүгээр зүйл бол хэн нэгэн өөрийгөө гүтгэсэн гээд л цагдаад хандахад прокурор, цагдаа нар шууд нөгөө хүнийг буруутай гэдгээр зүйлчлээд явчихдаг. Улмаар эрүүгийн хэрэг үүсгэсэн шууд таслан сэргийлэх арга хэмжээг чөлөөтэй авдаг. Хэзээ ч нөгөө хүнийг энэ буруугүй гэсэн цагаатгах талын нотлох баримтыг цуглуулдаггүй. Ийм өрөөсгөл талтай хуулийн заалт байгаа юм. Тэгэхээр ардчилсан Монгол Улсын энэ ардчилсан парламент Үндсэн хуулийн цэцийн гаргасан энэ дүгнэлтийг хүлээж авах ёстой. Хэрвээ бид хүлээж авахгүй бол хүний үндсэн эрхээс эргэж алхсан, ардчиллаас ухарсан ийм хэрэг болно. Тэгэхээр Улсын Их Хурлын эрхэм гишүүд та бүхэн кнопдоо хүрэхгүй байж энэ Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээж авна уу гэж уриалж байна.

Н.Учрал: Аюушийн Ариунзаяа гишүүн. Мөнхбаясгалан гишүүн санал хэллээ. Ариунзаяа гишүүн.

А.Ариунзаяа: Би юуны өмнө Цэцэд бас энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хэлэлцэж хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай гэж энэ заалтыг оруулсанд нь талархал дэвшүүлье дээ. Хуулиа бас мэддэг юм байна. Улсын Их Хуралд дүгнэлт гаргасан бол Улсын Их Хурал хэлэлцдэг юм байна гэдгийг бас мэддэг л юм байна шүү дээ. Болдог юм байна.

Гаргасан шийдвэр нь 2 үзүүртэй зүү шиг гарсан байна гэдгийг бас хэлмээр байгаа юм. Яагаад гэхлээр яг нэгтгэн дүгнэж байгаа энэ 32 дугаар хуудас, 33 дугаар хуудас дээрээ Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйл нь илт худал мэдээлэл тараахыг хориглох замаар хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд хууль бусаар халдахаас хамгаалахад чиглэсэн үзэл бодлоо бодлоо чөлөөтэй илэрхийлэх чөлөөнд тогтоосон хязгаарлалт мөн байна гээд дүгнэж байгаа байхгүй юу бас нөгөө талдаа.

Тэгэхээр 2 үзүүртэй зүйл шиг байгаад байгаа юм. Нэг талдаа энэ үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх нь зөв. Гэхдээ нөгөө талдаа бас Эрүүгийн хуулиар энийг илт худал мэдээллийг тараахыг хориглож байгаа нь зөв юм гэсэн бас ийм 2 талын мэдээлэл хийчхээд байгаа байхгүй юу. Тэгээд цаашлаад ингээд уншаад байхлаар Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйл нь эрх зүйн тодорхой байдалд тохирсон байх зарчим гэсэн нийтлэг шаардлагыг хангаагүй байна гэж байгаа юм.

Тэгэхээр сая яг Мөнхбаясгалан гишүүний хэлж байгаатай нэгэн адилаар маш өргөн хүрээнд олон нийтэд худал мэдээлэл тараасан гэдэг энэ шалгуур, хүрээ тодорхойгүй байгаагаас улбаалж ямар ч хамаагүй ямар ч хохирол нь хүртэл тодорхойгүй байгаа энэ асуудлууд дээр хэлмэгдүүлэн хариуцлага тооцох ийм нөхцөл байдлыг үүсгэсэн байгаа нь өөрөө буруу юм гэдэг ийм асуудлыг оруулж ирж байна гэж нэг талдаа харагдахаар байна.

Мөн түүнчлэн түүнд бичсэн байгаа асуудал нь худал мэдээлэл тараах гэмт хэрэгт хорих ял шийтгэлээс татгалзаж, торгох ялын хэмжээг бууруулсан нь тохирсон арга хэмжээ мөн боловч зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэхээр хуульчилсан нь тус эрх чөлөөг хэтрүүлэн хязгаарлах нөхцөлийг бүрдүүлсэн байна гэсэн ийм дүгнэлтийг гаргачхаад байгаа юм.

Тэгэхээр үндсэндээ энэ дүгнэлт нь худал мэдээлэл тараах, гүтгэх хариуцлага бол байх ёстой. Гэхдээ тодорхой байх ёстой, бас илүү юу гэдэг юм бэ дээ илүү зохицуулалтыг, нарийн зохицуулалтыг шаардаж байгаа юм байна гэсэн ийм дүгнэлт байгаа учраас энэ дүгнэлтийг хүлээн авах нь зүйтэй гэж үзэж байна.

Нэмэлт минутаа авчхаж болох болов уу? 26 секунд үлдчихээд байна.

Тэгээд үүн дээр би сууриалаад бас юу гэж хэлэх гээд байна вэ гэхлээр ер нь энэ хэн нэгнийг гүтгэх, худал мэдээлэл тараах эх үүсвэр нь их сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн байгууллагууд байдаггүй л байхгүй юу даа. Цаана нь захиалагч нь хэн бэ гэдэг нь хамгийн том асуудал. Тэгээд энэ дотроо Улсын Их Хурал, улс төрчид өөрсдөө энэ асуудалдаа.../минут дуусав./

Н.Учрал: Ариунзаяа гишүүнд нэмэлт 1 минут өгье.

А.Ариунзаяа: Тэгээд хэн энэ мэдээллүүдийг захиалаад байгаа юм, хэнд илүү ашигтай байгаад байгаа юм гэдгийг эргэн харах хэрэгтэй. Улсын Их Хурлын гишүүд ч гэсэн өнөөдөр энэ чуулганы танхимд худал мэдээлэл тараасан, хүнийг гүтгэснийгээ юу гэж боддог вэ гэхлээр өө би чуулганы танхимд хэлсэн үгнийхээ төлөө хариуцлага хүлээхгүй гэж боддог. Үгүй шүү дээ хуулиа унш. Улсын Их Хурлын тухай хуулийн 41.2 дээр гишүүн бусдыг гэмт хэрэгт холбогдуулан доромжлох, гүтгэхээс бусад тохиолдолд хуулиар хариуцлага хүлээхгүй гэж байгаа шүү нөхөд минь. Улс төрчид өөрсдөө өнөөдөр дүгнэлт хийх ёстой. Яагаад бусдыг гүтгээд байгаа юм, яагаад бусдыг доромжлоод байгаа юм, яагаад худал мэдээлэл явуулахад мөнгө тараагаад байгаа юм, хэнд захиалга өгөөд байгаа юм. Улс төрчид байхгүй юу. Тэгэхээр энд хэвлэл мэдээллийн байгууллагуудын буруу гэхээсээ илүүтэй улс төрчид өнөөдөр дүгнэлт хийх ёстой шүү нөхөд минь. Тэгэхээр энэ Цэцийн дүгнэлтийг авч, хүлээн авах нь зүйтэй. Хүлээн аваад харин илүү хуулиудаа тодорхой болгоод энэ гүтгэж байгаа бусдын өмнө.../минут дуусав./

Н.Учрал: Амгаланбаатарын Ганбаатар гишүүн үг хэлнэ, асуулт асууна.

А.Амгаланбаатар: Үг хэлье ээ. Эрүүгийн хуулийн 13.14-ийг энэ заалт энэ хуульд байх ёсгүй гэдэг зарчмын байр суурийг Их Хурлын гишүүн болсноосоо хойш холбогдох хурал, семинарт илэрхийлж явж байгаа. Учир нь юу вэ гэвэл гишүүн бид нар өндөр дээд албан тушаал хашиж байгаа төрийн албан хаагч нар бүгдээрээ энэ улс төрийн төрийн замыг сонгосон. Тэгэхээр бид нар энэ хардлагын субъект гэдгийг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Бид нарын нэр төрөө хамгаалах ганцхан арга бол зөв явах. Тэгэхээр энэ сэтгүүлчтэй маргалдах, үг хэлснийх нь төлөө, хэвлэн нийтэлснийх нь төлөө ялангуяа Эрүүгийн хуулиар маргалдана гэдэг ардчиллын зарчмаасаа ухарч байгаа юм. Олон улсын байгууллагуудын маш олон судалгаа ирсэн байгаа. Дотоодын байгууллагуудаас энэ “Глоб Интернэшнл”-ийн судалгаанууд байдаг. Ардчилсан орон юм бол хэвлэлийн эрх чөлөөтэй, үг хэлэх эрх чөлөөг нь чөлөөтэй тавьж тавьж өгсөн байх ёстой.

Тэгэхээр энэ үзүүлэлтүүд чинь яг энэ хуулийн заалтаасаа болж унаад байгаа юм. Олон улсад Монгол Улсын нэр хүнд. Тэгэхээр энэ заалтыг аваач. Ерөөсөө сэтгүүлч андуу ташаа бичсэн байдаг юм уу асуудал юу гэдэг юм буруу ташаа мэдээлсэн бол хариуцлага нь редакц дээр байна шүү дээ. Хэвлэлийн консул гэж байдаг. Өөрөө өөрийгөө шүүх, өөрөө өөрийгөө шийтгэх, өөрөө өөрийгөө үнэлж дүгнэх энэ систем чинь л хэвлэл мэдээллийн өөрөө өөртөө хяналт тавьж байгаа систем байхгүй юу. Тэгэхээр үүнийг ойлгоод Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг эрхэм гишүүд хүлээж авах хэрэгтэй.

Ингээд эрхэм гишүүдийгээ уриалъя. Монгол Улс ардчилсан байх ганц суурь ойлголт бол хэвлэлийн эрх чөлөө, хэвлэл нийтлэлийн эрх чөлөө. Үүнийгээ бид нар Эрүүгийн хуульд ингээд түгжчихээд, боомилчихоод явж болохгүй. Эрхэм гишүүд гараа хүрэхгүйгээр дэмжиж өгнө үү. Баярлалаа.

Н.Учрал: Ганбаатар гишүүн үг хэллээ. Хишигдэмбэрэлийн Тэмүүжин гишүүн.

Х.Тэмүүжин: Хууль зүйн шинжлэх ухаан хөгжих хэрэгцээ үнэхээр байна. Анх 2015 онд Эрүүгийн хуулиас гүтгэх болон доромжлох гэмт хэргийг авч хаясан юм. Яагаад авч хаясан бэ гэхээр энэ төрлийн гэмт хэргүүд иргэн эрхээ эдлэх гэхээсээ илүүтэйгээр хуучин удирдагчийн нэр төрийг хамгаалах, нам засгийг өргөмжилж дээш нь иргэнээсээ илүү үнэ цэнтэй байлгахад Эрүүгийн хуулийн тэр хэсгүүд ашиглагддаг байсан юм.

Гэтэл 19 онд худал мэдээлэл тараах гэдэг гарчиг доор гүтгэх гэмт хэрэг буцаж бичигдсэн. Буцаж бичигдэхдээ социализмын үеэсээ долоон дороор бас бичигдсэн. Яагаад ингэж хэлж байгаа юм бэ гэхээр энэ гүтгэх, худал мэдээлэл тараах гэдэг гэмт хэргийн ард төрийн байгууллага өөрөө гомддог болсон иргэндээ. Бидний ажил хэргийн нэр хүндэд халдаж байна гэдэг байдлаар төрийн байгууллагууд өөртөө байгаа эх үүсвэр, хуулийн боломжоо ашиглаад иргэнээ Эрүүгийн хуулиар айлгадаг жишиг тогтож эхэлсэн. Шүүхээс тийм шийдвэр гаргаж эхэлсэн. Хуулийн байгууллага дээр цагдаа дээр шалгаж байгаа хэргүүдийн дийлэнх нь ерөөсөө төрийг шүүмжилж болохгүй, даргын үйл хэргийг өөрөөр харж болохгүй гэдэг ийм хандлага руу нийгмийг түлхэж эхэлсэн.

Тийм учраас Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтэд дурдагдсан маш олон саналтай санал нэг байна. Бид бол Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээж авах ёстой. Гэхдээ дахиад бид Үндсэн хуулийн цэцтэй холбоотой хууль тогтоомжоо боловсронгуй болгох хэрэгцээ байна гэдэг харагдаж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийг уншаад үзээрэй. Үндсэн хуулийн цэц хууль Үндсэн хуульд нийцэж буй эсэхээр дүгнэлт гаргана гэж бичсэн байгаа. Үндсэн хууль зөрчсөн гэдэг дүгнэлт гаргах эрхгүй. Гэтэл одоо хүртэл бид Улсын Их Хурал дээр Үндсэн хууль зөрчсөн гэдэг Цэцийн дүгнэлтийг авч хэлэлцэж байгаа юм. Үндсэн хуулиа бид Цэц нь ч тэр, Улсын Их Хурал нь ч тэр зөрчмөөргүй байна. Үндсэн хууль дээр маш тодорхой байгаа. Үндсэн хуулийн цэц дүгнэлтээ Улсын Их Хуралд оруулна гэж хэлж байгаа. Гэтэл одоо Үндсэн хуулийн цэц зүгээр хаалга давуулж шиддэг болсон. Заримдаа энэ дүгнэлтийг Улсын Их Хурал хэлэлцэж болохгүй гэж хэлдэг болсон. Аль аль нь Үндсэн хуулиа дагаж мөрдөж дээдлэх тухай ярихгүй бол үндсэн хуулийн чинь манаач өөрөө Үндсэн хуулийг тогтоогч болоод өөрөө Үндсэн хуулийг үгүйсгэгч болоод хувирчихсан байгаа энэ асуудлыг бид бас эргэж харах ёстой.

Гэхдээ өнөөдрийн энэ Үндсэн хуулийн дүгнэлт бол иргэний үндсэн эрхтэй холбоотойгоор маш сайн үндэслэлтэй маш сайн гарсан шийдвэр. Гэхдээ дахиад бид хэд Үндсэн хуулийн цэцийг үнэхээр Үндсэн хуулийн шүүх болгоё гэж бодож байгаа бол иргэний үндсэн эрхийн холбоотой маргааныг шийддэг эрх мэдэлтэй болгох хэрэгтэй. Тэгэхгүй бол Үндсэн хуулийн цэц өөртөө байхгүй Улсын Их Хурлын үйл ажиллагааг Үндсэн хууль зөрчиж байна уу үгүй юу гэдэг бараг л шийдээд явж байгаа шүү дээ. Үндсэн хуулиар Үндсэн хуулийн цэцэд ийм эрх олгоогүй. Гаргасан шийдвэр дээр дүгнэлт гаргах эрх л байгаа.

Н.Учрал: Батбаатар гишүүн. Энэ хариулах юм байна. Баттөмөрийн Энхбаяр гишүүн асуултад хариулна. Тэмүүжин гишүүн асуусан.

Б.Энхбаяр: Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хувьд бас нэг ойлголтын залруулга гарахгүй бол сая хэлэлцүүлгийн шатад ийм юм яваад, явчих явчих шиг боллоо. Цэц энэ гүтгэсэн, хүнийг гүтгэж байгаа энэ харилцааг ерөөсөө Эрүүгийн хуулиар зохицуулж болохгүй гэж хэлээгүй шүү. Ийм ийм гэмт хэрэг байж болохгүй гэж Цэцийн дүгнэлтэд байхгүй. Энийг 1 дүгээрт залруулчихмаар байна.

2 дугаарт, Цэцийн дүгнэлтэд хүний итгэл үнэмшилтэй байх эрхийг зөрчсөн гэж бас Цэц үзээгүй. Итгэл үнэмшилтэй байх Үндсэн хуульд заасан эрхийг зөрчөөгүй байна гэж үзсэн шүү. Та бүхэн тэр Цэцийн дүгнэлтийн 2 дахь заалтыг нь хараарай. Цэцийн дүгнэлтийн бид үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний асуудлыг ярихдаа нөгөө талд нь савах ийм эрсдэлийг гаргаж яриад байгаа юм. Нийтдээ 5 жилийн хугацаанд 840 орчим хүн энэ гэмт хэрэгт ял шийтгэгдсэн байна. Энэний 88.5 хувь нь цахим орчинд хүн гүтгэсэн байгаа. Цахим орчинд шүү. Хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчид бол тухайн ... шийдэгдсэн хүний 15 хувиас хэтрэхгүй байгаа.

Тэгэхээр энэ нөгөө хэвлэн нийтлэх эрх чөлөөтэй ганцхан холбоотой асуудал биш шүү. Ерөөсөө хүн хүнээ гүтгэж болдог юм уу, доромжилж болдог юм уу, хүний нэр төр хамгаалагдах ёстой юм уу, хамгаалагдах ёсгүй юм уу гэдэг асуудал цаана нь яригдана. Бид эрх чөлөөний тухай үзэл санааг ярьж байгаад ерөөсөө хүний нэр

төр, алдар хүнд, хуулийн этгээдийн нэр төрийг Эрүүгийн хуулиар хамгаалахгүй болгох юм руу явж байгаа. Энэ бол жил ч явахгүй. Хамгийн ардчилсан гэж байгаа бүх улсад хүний нэр төр Эрүүгийн хуулиар хамгаалагддаг. Бүх улсад. Та бүхэн Эрүүгийн хуулиар хамгаалагддаггүй хүний нэр төрөө хамгаалдаггүй тийм улс олоод ирээрэй.

Харин би энэ судалгаа харьцуулаад байж байна. Харин улс орнууд хорих ялтай байгаа, өндөр торгуультай байгаа. Зорчих эрх хязгаарлах бид нар харин манай улс 450 мянгаас 1.2 сая төгрөгөөр торгох ялтай, зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэлтэй байгаа. Бид нар хорих ял байхгүй улс шүү харин. Эсрэгээрээ энэ харьцуулсан судалгаанд оруулсан улсуудаас манай улс Эрүүгийн хуулиараа хамгийн бага эрүүгийн ял шийтгэл ноогдуулдаг улс байгаа. Хүний нэр төрийнх шүү. Хүний нэр төр яснаас илүү үнэ цэнтэй гэж ярьдаг. Нэр хугарахаар яс хугар гэж ярьдаг. Хүний нэр төрд халдсанаас болж амиа хорлодог. Хүний амины үнэтэй шүү. Ялангуяа бизнесийн компаниудын нэр төр хэдэн тэрбумаар үнэлэгддэг. Ялангуяа том дэлхийн үндэстэн дамнасан корпорацуудын “Apple” брэндийн юм уу, “Кока Кола” брэндийн оюуны өмч бол тэрбум долларуудаар яригдана. Ийм үнэ цэнтэй эд шүү. Энэ дээр ямар ч ял шийтгэл байх ёсгүй тухай асуудал нөгөө талдаа нийгмийн ёс суртахуун, үндэсний аюулгүй байдал, сахилга хариуцлагатай бас холбоотой асуудал байгаа шүү гэдэг.../минут дуусав./

Н.Учрал: Тэмүүжин гишүүн тодруулна.

Х.Тэмүүжин: Бид хэд нэг ийм алдаа гаргачхаад байгаа гэдгээ бас хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Хүн гүтгэх гэдэг бол уламжлалт гэмт хэрэг. Энэ дундад зууны үеэсээ л дэлхий нийтээрээ байсан гэмт хэрэг. Худал мэдээлэл тараах гэдэг сүүлийн 15, 6 жилд бий болж байгаа шинэ төрлийн гэмт хэрэг. Гэтэл монголчууд бид худал мэдээлэл тараах гэдэг шинэ гэмт хэргийн гарчгийн доор гүтгэх гэмт хэргээ бичээд холиод тавьчихсан. Худал мэдээлэл тараах гэдэг гэмт хэрэг юуг илэрхийлж байна вэ гэхээр бусад улс орнуудад. Гэхдээ анх санаачилга гаргасан нь бас тийм зөв гэж хэлэхээр улс орнуудад гараагүй. Хүчирхийллээр, захиргаадлын аргаар асуудлаа шийддэг улс орнууд байсан юм. Сүүлийн үед ардчилсан улс орнууд энийг, гэмт хэргийг хуульчилж байна. Энэ нь худал мэдээлэл тараа, хэн нэгнийг гүтгэхгүй, нэр төрд нь халдахгүй худал мэдээллийн улмаас нийгэмд талцал үүссэн, хүчирхийлэл гарсан, их хэмжээний эд хөрөнгө сүйтгэсэн, хүн амиа.../минут дуусав./

Н.Учрал: Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгчөөр Баттөмөрийн Энхбаяр гишүүн оролцсон. Тэгээд Энхбаяр гишүүн хариулна.

Б.Энхбаяр: Тийм Тэмүүжин гишүүн бид 2 нэг зүйл дээр санал нэг байгаад байгаа юм. Энэ илт худал мэдээлэл тараах гэдэг энэ зүйл шинжээчийн хувьд буруу томилогджихсон. Зориуд санаатай гүтгэлэг тарааж байгаа, захиалгатай худлаа гэдгийг нь мэдсээр байж шүү. Энэ хариуцлагатай байх ёстой шүү. Санамсар болгоомжгүй мэргэжлийн алдаа, зориуд санаатай биш энэ мэдээлэл тараасныхаа төлөө эрүүгийн хариуцлага ноогдох ёсгүй. Энэ 2 шинжийг ялгаагүйгээр одоогийн Эрүүгийн хууль бичигджихсэн байгааг Үндсэн хуулийн цэц тодруулсан. Тэрнээс биш Үндсэн хуулийн цэц хүнийг гүтгэж болно гэж хэлдэг байгууллага бас биш шүү. Үндсэн хуульд хүний нэр төр халдашгүй байна гэж байгаа. Энэ хүний нэр төр бие биеийнхээ нэр хүндийг хамгаалах бол хүн бүрийн

үндсэн үүрэг гээд Үндсэн хуульд бас бичээтэй байгаа. Энийг нь хамгаалах нь төрийн үүрэг гээд бас Үндсэн хуульд бичээтэй байгаа. Энэ хамгаалах үүргээ төр хэрэгжүүлэхгүй байх боломжийг.../минут дуусав./

Н.Учрал: Батын Батбаатар гишүүн.

Б.Батбаатар: Өнөө оройны амгаланг эрье. Энэ Цэцийн дүгнэлттэй холбоотой би ч уг нь муу ч үгүй МУИС-ийн Хууль зүйн сургууль төгссөн юм байгаа юм. Тэгээд хуулийн нэр томьёо, техник хэрэглээд яриад байж бас болно. Тэгэхдээ энэ удаа бас арай өөрөөр хэлье гэж үзэж байна. Тодорхой зарим жишээг ярья. Тэгэхдээ бусад хүн дээр тохиолдсон жишээг ярихгүй. Манай энэ Тэмүүжин би үнэн, худлыг нь мэддэггүй энэ сайн ах гээд л улс даяар цоллуулсан. Хариуг нь ойлгоогүй учраас үнэн ч юм уу худлаа ч юм уу ойлгодоггүй юм. Тэгэхдээ бид нарыг гүтгэлэг болов уу гэж хувьдаа боддог юм.

Улсын Их Хурлын дэд дарга Пүрэвдорж энэ чуулганы танхимд надад хэлсэн. Улсын Их Хурлаас орон байрны дэмжлэг 390 сая төгрөг авсан чи хулгайч гэж хэлсэн. Их Хурлын дэд дарга нь тэгж хэлж байна гэдэг чинь юу гэсэн үг юм. Улсын Их Хурлын 40-өөд гишүүн Их Хурлаас орон байрны дэмжлэг авсан гэдэг зүйлийг нийтэд, олон нийтэд цацсан. Энэ тухай Их Хурлын Тамгын газраас асуугаад энд нь хариулт өгөөрэй гэсэн алга дарам цаас нэг ширхэг ч гишүүн дэмжлэг аваагүй гэдгийг хэлсэн. Их Хурлын дарга энэ дээрээ анхаарч бас хэлэх хэрэгтэй. Улсын Их Хурлын гишүүд орон байрны дэмжлэг авсан хүн нэг ширхэг байхгүй. Энэ бол худал гүтгэлэг гээд. Дээрээс нь энэ төсөв Засгийн газар энэ төрийн байгууллагууд чинь Хэмнэлтийн тухай хуулиар нөгөө өөрсдийнхөө зөв, бурууг олон нийтэд няцаалт хийгээд хүргэх тэр зардал, санхүү нь байхгүй шүү дээ. Лайвчид байдаг юм уу орилдог хэдэн хүмүүс замбараагүй өндөр өртөгтэйгөөр, төлбөртэйгөөр мэдээлэл тараадаг. Тэр нь ар араасаа үргэлжилдэг.

Өнгөрсөн наадмын өдрүүдээр Хятадад намын шугамаар айлчилсан айлчлалын зургийг гаргаж ирээд Бразил явсан гээд л гаргаад тавьчихсан байсан. Кени явсан гээд л өөр хаашаа хаашаа гэлээ. Ингээд худал гүтгэлгүүд явуулаад байдаг энийг бид нар яах ёстой юм? Улсын Их Хуралд нэг бол намайг аваагүй байхад өөр гишүүддээ орон байрны дэмжлэг өгчихсөн юм уу, тэгээд үг дуугарч чаддаггүй юм уу? Ингээд гүтгэгчдэд нь эрх их олдоод байдаг. Хэлмэгдүүлж байгаа хүмүүст нь эрх нь олддоггүй. Тухайн хүнийг үнэхээр идчихсэн уучихсан хулгайч аятай болгоод хаячихдаг ийм байдалтай яваад байгаа юмыгаа бид нар яаж шийдэх юм бэ?

Дээрээс нь энэ жил 229 хоногийн дараа Риогийн 3 конвенцын нэг Цөлжилтийн эсрэг конвенц Талуудын 17 дугаар Бага хурал Улаанбаатарт болно. 70 гаран өөр улсын Байгаль орчны сайд нараас Монголд айлчилна, очно, хуралд оролцоно, шийдвэр гаргалтад оролцоно оо гэдгийг өөрийн нүүр.../минут дуусав./

Н.Учрал: Товлосон асуудлыг хэлэлцэж дуустал хуралдааныг сунгалаа. Батбаатар гишүүнд нэмэлт 1 минут өгье.

Б.Батбаатар: 70 гаруй дэлхийн Байгаль орчны сайд нар манай энэ хуралд ирнэ гэсэн. COP-той холбоотой гүтгэлэг замбараагаа алдаж явж байгаа. Зарим нь мэддэг юм байна лээ. Монголд яагаад энэ COP-ын эсрэг ийм болоод байна аа гэж.

Тэгэхээр энийг яагаад би ярьж байна гэхлээр нөгөө өөр хүний жишээн дээр юм уу ярихаар бусдад буруу ойлгогдох байх. Хуулийн техник хэрэгсэл, үг хэллэг ашиглаад ярихаар дутуу үүрэх байх гэж бодож энэ олон гүтгэлгүүд ар араасаа үргэлжилж гарч байгаа учраас. Өнгөрсөн онд энэ оны хавар, намар манай намын Их Хурал хуралдахдаа би намынхаа бүх гишүүдэд тов тодорхой хэлж өгсөн. 2027 онд Иргэний зориг ногоон нам Ерөнхийлөгчид нэр дэвшүүлнэ. Монгол Улсад Ерөнхийлөгчид нэр дэвших олон олон эрдэмтэй мэргэд мундаг хүмүүс байгаа. Тэрнээс хойш энэ бас л идэвхжиж байгаа. Энэ чуулганы танхимд.../минут дуусав./

Н.Учрал: Энхбаяр гишүүн хариулна.

Б.Энхбаяр: Яах вэ энэ улс төрчид Цэцийн шийдвэрт нэг байгаа би энэ дээр өөрөө санал, хууль санаачилж байсан хүн. 21 оны 3 сард нийтийн албан тушаалтан өөрийгөө төлөөлж байгаа биш цаанаа ард түмнийг төлөөлж байгаагийнхаа хувьд илүү хүлээцтэй, тэвчээртэй байх ёстой гэдэг шаардлага тавигддаг. Энийг анх шийдсэн нь Америкийн Дээд шүүх ийм шаардлага тавьсан. Энэ шаардлага бас дэлхий нийтээр нутагшдаг. Тэгэхээр ард түмнийг төлөөлж байгаа хувьдаа, ард түмний нэрийн өмнөөс шийдвэр гаргаж байх хувьдаа олон нийт, хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчдийн албаны үүргээ хэрэгжүүлэхтэйгээ холбогдсон холбоотойгоор гарсан тэр хардлага, сэрдлэг дээр матрын нулимс унагаад гомдоод байж болохгүй гэдэг шаардлагатай би санал нэг байдаг.

Тийм ч учраас энэ гүтгэх гэдэг дээр би тайлбар оруулъя гэж. Тэмүүжин гишүүн түрүүн хэлээд байна шүү дээ төрийн байгууллагууд гомдоод байдаг болчихсон гэж. Цагдаагийн байгууллага нь, прокурорын байгууллага нь, Шүүхийн ерөнхий зөвлөл нь өөрсдөө гомдоод байгаа шүү дээ. Тэгээд хэвлэлийнхнийг ял шийтгээд байгаад энэ дээр асуудал үүсээд байгаа байхгүй юу. Ялангуяа сая КОВИД-ын жилүүдийн юм болсон. Онцгой байдлын байгууллагын гомдлоор 1 иргэнд сошиал орчинд пост хийсэн гээд ял шийтгэчихсэн байгаа байхгүй юу. Тэгэхээр төрийн байгууллага гэдэг бол ерөөсөө гомдож болохгүй гэдэг. Нийтийн албан тушаалтан албаныхаа чиг үүрэгтэй нь холбоотойгоор гүйцэтгэсэн чи авлига авсан байна, чи албан тушаалаа ургуулан ашигласан байна, чи үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн байна ийм асуудал дээр гүтгэлээ гэж иргэнийг болон сэтгүүлчийг хуулийн байгууллагад хандаж, гомдол гаргаж болохгүй шүү гэдэг шаардлагыг дээр тодотгох шаардлага байгаа юм.

Өөрөөр хэлбэл, энэ заалт одоогийнхоороо болохгүй байна гэдэг дээр Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хувьд би өөрөө энийг хүлээн зөвшөөрөөд энийг янзлах ёстой гэж Цэц дээр бас хүлээн зөвшөөрч ярьсан. Харин албан тушаалтан чинь бас нөгөө талаар хүн байгаа. Хүний нэр төрд халдаж болохгүй. Яагаад гэхээр хүн гэдэг хувьдаа тэр чинь яг бусад хүмүүстэй адилхан нэр төртэй байхгүй юу. Чи албан тушаалтан учраас чамд нэр төр гэж байх ёсгүй. Чамайг гүтгэж болно гэж Цэц ингэж шийдвэр гаргаж бас болохгүй байхгүй юу даа. Цэцийн шийдвэрт нэр төрийг нь ялгаагүй гаргачихсан. Би жишээлбэл улс төрч хүн бол өөр дээрээ жишээ авах их буруу гэдэг ийм байна лээ.

Тэгэхдээ би өөр дээрээ гарсан нэг жишээ хэлье. Намайг бага насны хүүхдийг автомашин барьж байгаад жолоодоод дайраад алчихсан гэдэг гүтгэлгийг

сонгуулийн үеэр тарааж байсан. Би албан тушаалтныхаа хувьд хүүхэд дайраагүй байх нь байна шүү дээ. Хүнийх нь хувьд гүтгээд байгаа биз дээ, нэр төрд халдаад байгаа биз дээ? Би яагаад ийм худлаа гүтгэлэг дээр би яагаад гомдол гаргах эрхгүй байх ёстой юм. Албан тушаалтныхаа хувьд, чи хууль тогтоогчийнхоо хувьд чи ийм албан тушаал хашиж байхдаа чи ингээд албан тушаалын байдлаа ургуулан ашигласан байна гэж хардаж сэрдэж байгаа үйлдэл дээр гомдол гаргах ёсгүй. Энэ зааг, ялгааг нь яриад байгаа байхгүй юу. Нэр төр, тэгтэл Цэцийн шийдвэр дээр болохоор нийтийн албан тушаалтны нэр төр ерөөсөө ингээд чи ямар ч гүтгэлэгт чи тэвчээртэй байх ёстой гээд байгаа байхгүй юу. Чамайг хүүхэд дайрчихсан гэж гүтгээд байна шүү дээ. Энэ Батбаатар гишүүнийх албан тушаалтныхаа хувьд, Их Хурлын гишүүнийхээ хувьд та орон сууцын дэмжлэг авсан гэж гүтгүүлсэн юм байна шүү дээ та Пүрэвдорж гишүүнд. Энэ асуудал дээр та цагдаад хандах ёсгүй. Иргэний журмаар явах ёстой байхгүй юу. Иргэний шүүхээрээ, нэр төрөө сэргээлгэхээр, цагдаад гомдоллоод байх ёсгүй. Ер нь бол цагдаад гомдоллоод байдаг улс төрчид тийм олон биш юм бай.../минут дуусав./

Н.Учрал: Батбаатар гишүүн тодруулна.

Б.Батбаатар: Өнөөдөр зүгээр яах вэ энүүхэнд тэгээд гишүүдэд хэлэхэд бас төрсөн өдөр байгаа юм. Нэг юм гүйцээгээд асуучихъя. Их Хурлын дарга Учрал хариулаад өгчихвөл их сайн байна. Улсын Их Хурлын 40 гаран гишүүн, тэр дотроо Батбаатар 390 гэсэн байх сая төгрөгийн орон байрны дэмжлэг татвар төлөгчдийн мөнгөнөөс авсан гээд. Үгүй энэ чинь ганцхан миний нэрийн асуудал биш л дээ. Магадгүй 40-өөд гишүүнд өгчхөөд би тэрийг нь мэдэхгүй явж байгаад дунд нь нэр орж ирэхээр нь гайхаад асуугаад байж болно шүү дээ. Тэгэхээр энэ хариултыг бас өгчихмөөр байх юм.

Дээрээс нь саяын Энхбаяр сайдын хэлдгээр энэ чинь бид нар бас төрийн албан тушаалтны хувьд юун дээр гомдох вэ, юун дээр гомдохгүй хаяж болох вэ тэр зэргийн зааг, хязгаараа мэднэ шүү дээ. Тийм болохоор энд энэ дээрээ энэ хуулийнхаа тэр нарийн зохицуулалтаа хийж явахгүй бол энэ чинь ер нь цаашдаа их олон юманд.../минут дуусав./

Н.Учрал: Улсын Их Хурлын гишүүн Батын Батбаатар тодрууллаа. Тэгээд Улсын Их Хурлын Энхбаяр гишүүн хариулах уу? Нэмэлт 1 минут.

Б.Энхбаяр: Батбаатар гишүүн манай хүлээцтэй гишүүний нэг л дээ. Хүлээцгүй энэ заалтыг буруугаар ашиглаад өөрийг нь албан тушаалтных нь хувьд хардаж сэрдсэн хэвлэл мэдээллийн байгууллагыг цагдаад өгөөд хэрэг үүсгүүлээд ингээд амыг нь үдэх гэдэг сонирхолтой улс төрчид байна байна. Энийг бид хүлээн зөвшөөрөх ёстой. Цэц энийг хэлж өгсөн. Өөрөөр хэлбэл, энэ заалт хэт өргөн тодорхой биш байгаа учраас энийг зарим тохиолдолд ингэж урвуулж ашиглах ийм бололцоотой байдлаар хуульчлагдчихсан байна. Энийгээ янзлаач гэдэг сануулгыг хууль тогтоогчид өгсөн. Би энийг хүлээн зөвшөөрөөд байгаа юм. Тэрнээс биш Цэц бол ерөөсөө энэ гүтгэх гэдэг зүйл анги Эрүүгийн хуульд байх ёсгүй гэж шийдээгүй шүү. Ийм шийдвэр гаргачихсан юм шигээр бас бас ойлгогдоод энд яригдаад байгаа учраас.../минут дуусав./

Н.Учрал: Энэ Цэцийн дүгнэлтийг хүлээж хэрвээ авбал бид нар хуульдаа өөрчлөлт оруулах эрх нь Хууль зүйн байнгын хороонд хадгалагдаж байгаа.

Тэгэхээр Их Хурлынхаа Хууль зүйн байнгын хороон дээр энэ Цэцийн дүгнэлттэй холбогдуулаад тэр худал мэдээлэл түгээх гэдгийг юуг ойлгох вэ гэдгийг зааглаж өгөх асуудал байхгүй юу. Тэр хуулиа илүү тодорхой нэг мөр хэрэглэх бололцоотой бол оо гэдэг Цэц тайлбар өгчхөөд байна шүү дээ. Тэрнээс биш энийг авна, авахгүй гэдэг нь Эрүүгийн хуулиас энэ заалтыг бүтэн авах гээд байгаа ойлголт огт биш энэ Энхбаяр гишүүний хэлээд байгаа асуудал. Тэгээд энэ өөрөө үүнийг ашиглаад иргэдийн мэдэх эрхэд халдах, энэ хүний жам ёсны эрхэд халдах үйлдэл цаашид гарах вий гэдэг дээр Их Хурлын гишүүд болгоомжтой хандах ёстой л гэдэг ийм байр суурийг хэлээд байгаа юм.

Батбаатар гишүүн сая хэлж байна. Сая Энхбаяр сайд ч хариуллаа. Тэгээд иргэний журмаар тэр асуудлаа шийдэх хэрэгтэй. Тэр хэн хэлсэн юм бэ дээ таныг тэгж гүтгэж, энэ чинь иргэн болгон л хэрвээ хэвлэл мэдээллээр гүтгүүлсэн бол, хэн нэгэнд гүтгүүлсэн бол шүүхдээ хандаад ингээд асуудлаа шийдүүлээд явдаг. Тэгээд өөрийнхөө нэр төрийг сэргээлгэх ажлаа хийх хэрэгтэй. Нийтийн албан тушаалтан хүмүүс олон нийтийн анхаарлын төвд байгаа.

Тийм учраас ёс зүйтэй, зарчимтай, хариуцлагатай ажиллах ёстой. Хэрвээ худал, үнэн гүтгэчихсэн бол цаг тухайд нь нотлох баримтаа гаргаж ирээд, тайлбарлаад өөрийнхөө нэр төрийг сэргээгээд ингээд бусад иргэдийнхээ адилаар хууль хяналтын байгууллагадаа ханд. Ерөөсөө Их Хурлын гишүүд нь илүү эрхтэй, иргэд нь дутуу эрхтэй гэж хаана ч байхгүй шүү дээ. Энгийн иргэд ч гэсэн янз бүрээр хэвлэл мэдээллээр гүтгүүлж л байна. Тийм биз дээ. Тэгэхээр тэр талд анхаарна биз.

Их Хурлын гишүүн, Уур амьсгалын өөрчлөлтийн сайд Батын Батбаатарт төрсөн өдрийн мэнд хүргэе.

Үгүй энэ чинь энэ чинь өнөөдөр бас төрсөн өдөр болж байна шүү дээ. Та өөрөө ийм. Үгүй үгүй Тамгын газраас юун дээр мөнгө гаргах юм? Та наадхаа тийм би яг хаана, хэзээ, хэн тэгж хэлснийг бас нөгөө бүрэн мэдээгүй байна л даа. Тийм учраас би тэр дээр анхааръя. Тамгын газраас Батбаатар даргад ямар нэгэн тийм орон сууцын дэмжлэг өгөөгүй биз дээ? Би чинь одоо бас сар болоогүй байна шүү дээ. Тийм учраас би өнгөрсөн хугацаанд хэн ямар дэмжлэг авсныг би мэдэхгүй байна.

Тэгэхээр Тамгын газар албан ёсны тайлбар өг. Хэн тэнд Батын Батбаатар даргыг тэгж хэлсэн юм. Тэгэхээр албан ёсоор тайлбарыг танд Батбаатар дарга танд хүргүүлнэ. Тэгж бас илтэд бас хүнийг гүтгэж болохгүй. Тийм Тамгын газраас янз бүрийн байр савны дэмжлэг үзүүлээгүй бол албан ёсоор танд тайлбарыг хүргүүлье Батбаатар даргаа танд. Тэгээд би тэрийг хүргүүлье.

Танд төрсөн өдрийн мэнд хүргэе Батбаатар даргаа. Батбаатар даргад төрсөн өдрийн мэнд дэвшүүлье. Эрүүл энх, сайн сайхныг хүсье.

Батбаярын Жаргалан гишүүн.

Б.Жаргалан: Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр заалт Үндсэн хуульд нийцсэн эсэх талаар Үндсэн хуулийн цэц овоо аюулын дүгнэлт гаргаад ирүүлчихсэн байхад өнөөдөр Хууль зүйн байнгын хороо хуралдаад тэгээд хүлээж авахгүй гэсэн

шийдвэр олонхоороо гаргачихсан байх юм. Бид хэд энэ олонхын бүлгийн гишүүдэд, эрх баригч намын гишүүдэд хэлмээр байгаа юм. Хэдүүлээ уриа лоозонг ярихлаараа нэг л их хүний эрх, эрх чөлөөг хамгаалдаг, нэг л их тийм эдийн засгийн эрх чөлөөг баталгаажуулдаг хүмүүс болчихдог. Тэгээд яг ийм бодит үйлдэл дээрээ дандаа ийм байх юм. Үгүй тэгээд ийм постер, плакат хийх болох дээрээ ингээд дандаа ийм гоё ийм уриа лоозонтой.

Тэгээд л холбогдох ийм үйлдэл гаргаад ирэхлээрээ дандаа энэ эрх, эрх чөлөөний эсрэг явна. Өнгөрсөн хугацаанд байна шүү дээ хар аа, 10-н жилийн хугацаанд Монгол Ардын нам үнэмлэхүй олонхоороо дангаараа засаг барьсан шүү дээ. Тэгээд ийм 10-н жилийн хугацаанд ийм ийм олон журам, хүний эрх, эрх, эрх чөлөөг зөрччихсэн гээд өөрөө өөрсдөөсөө айгаад, өөрөө өөрсдийгөө баалаад ингээд байж байдаг. Тэгээд өнөөдөр энэ энэ Хууль зүйн байнгын хорооны шийдвэр чинь энийг чинь л баталгаажуулж байна шүү дээ. Угаасаа анхнаасаа л ерөөсөө сэтгэлгээ нь ийм. Тэгээд хэдүүлээ ийм уриа, лоозонг ярьж нэг нэгнийгээ эсвэл хуурахаа болих хэрэгтэй.

Өнгөрсөн хугацаанд энэ ардчиллаас ухарч байна. Энэ хүний эрх, эрх чөлөөнөөс ухарч байна, энэ чөлөөт хэвлэл байхгүй боллоо, хүмүүс үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх ямар ч эрх чөлөөгүй боллоо, байнгын айдастай боллоо энэ тэр гээд яриад яриад байхад Хууль зүйн сайд нь ингээд компанийн алдар хүнд яриад сууж байж бас болохгүй шүү дээ. Энэ чинь ингээд шал өөр асуудал бүүр ийм юу гэж ч хэлмээр юм бэ дээ нээрээ ингээд үг олдохгүй байгаад байна. Ямар ч байсан гэсэн Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар энэ Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээж аваад үүн дээр гишүүд тэр Байнгын хорооны дүгнэлт, эсрэг гарсан дүгнэлт дээр кнопдоо хүрэхгүй татгалзсан санал өгөөд тэгээд дараа нь тэр ажлын хэсгээ гаргаад энэ хуульдаа өөрчлөлт оруулаад явах ёстой биз дээ зарчим нь. Тэгэхгүй бүгдээрээ л нэг л их тийм ардчилалд хайртай, хүний эрх, эрх чөлөөнд хайртай, Үндсэн хуульдаа хайртай хүмүүс байж байсан хэр нь яг ийм суурь асуудал дээрээ болохлоороо шал өөр ийм үйлдлүүд гаргаад байж болохгүй шүү дээ та минь ээ. Үнэхээр итгэл төрөхгүй байгаад байна шүү дээ. Санал хэллээ. Тайлбар ерөөсөө хэрэггүй.

Н.Учрал: Их Хурал Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хэлэлцэж байна. Тэгэхээр Их Хурлынхаа танхимд 5 нам, эвслээс бүрдсэн парламент ажлаа хийнэ. Нам, улс төрийн ажлыг энд хийхгүй шүү. Жаргалсайханы Золжаргал гишүүн.

Ж.Золжаргал: Үндсэн хуулийн цэцээс гаргасан дүгнэлтийг дэмжиж байгаа. Хууль зүйн байнгын хорооноос гаргасан шийдвэрийг дэмжихгүй байгаа. Мэдээж худлаа мэдээлэл тараагаад хүнийг гутааж доромжлоод байх юм бол хариуцлага хүлээлгэмээр байлгүй л яах вэ. Гэхдээ Эрүүгийн хууль дээр худал мэдээлэл тараасан гэдэг 13.14 чинь хэтэрхий ерөнхий, эвгүй нь цаг таарах юм бол яаж ч эргүүлээд сэтгүүлч нэг үг хэлсэн хүнийг аваачаад мушгиад ялалчхаж болохуйц. Тэр нь бас бодит амьдралаар батлагдчихсан учраас хүний үндсэн эрхийг хязгаарлаж байна гэсэн дүгнэлт хийсэн гэж ойлгосон.

Тийм болохоор энэ Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээж авах нь зүйтэй гэж үзэж байгаа. Эрүүгийн хууль дээр юуг худал мэдэл тараасан гэх юм, юуг гүтгэлэг гэх юм, тэр ажлуудаа харин дараа нь ажлын хэсэг гаргаад хийх ёстой гэж үзэж байна.

Тийм учраас би энэ Хууль зүйн байнгын хорооны дүгнэлтийг хүлээж авахгүй гэдэг байр суурьтай байна. Үүнд уриалж байна. Баярлалаа.

Н.Учрал: Асуулт асуугаагүй шүү дээ. Саналаа л хэллээ. Хүний эрхийн дэд хорооны дарга хаана байна? Хүний эрхийн дэд хорооны дарга хаана байна? Хүний эрхийн дэд хорооны дарга гэсэн Эрдэнэболд гишүүн билүү? Тийм, манай энэ Баасанжаргал гишүүн бараг л Хүний эрхийн хорооны дарга шиг ажиллаж байгаа шүү. Баасанжаргал гишүүн асуулт асууя.

Х.Баасанжаргал: Баярлалаа. Сая манай Хууль зүйн байнгын хороон дээр энэ Цэцийн дүгнэлтийг хүлээж аваагүй. Эсрэг кноп дарсан хүмүүс нь Ардчилсан намынхан бас байсан шүү. Алтанхуяг гишүүн байсан. Ганбаатар гишүүн байсан. Тэгээд яг үнэндээ ингээд яг хүний эрх, эрх чөлөөний төлөө юм уу гэхээр биш байдаг энэ ах нартаа бас та нар хэлмээр байх юм. Сөрөг хүчин бас сөрөг хүчин шиг л баймаар байна. Ерөөсөө энэ ажлаа хийхгүй байгаа шүү дээ. Тэгээд бид нарын энэ би сая Хууль зүйн байнгын хорооны дүгнэлтийг уншихдаа хэлсэн би өөрөө санал нэгдэхгүй байгаа. Энэ Үндсэн хуулийн цэцийн 10 дугаар дүгнэлтийг хүлээж авах ёстой гэдэг ийм байр суурьтай байгаа. Бид нар тэгэхдээ энэ манай Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжих гэдэг байдлаар энэ санал хураалт явагдах байх гэж бодож байна.

Тэгээд энэ Цэцийн дүгнэлтийг үндэслээд бид нар ажиллаад энэ хүнийг гүтгэх, доромжлох, худал мэдээлэл тараах гээд энэ чинь бас дотроо олон ялгаатай. Үүсээд байгаа хор уршгийн хувьд бас ялгаатай. Энгийн иргэнд үү, нийтийн албан тушаалтнууд гээд бас ялгаатай гэх мэтээр маш ийм нарийн нюанстайгаар бид нар хуульчлах ийм боломж гарч ирж байна гэж харж байгаа. Нэг талдаа улс төрийн шахалт бий болж байгаад би хувьдаа баяртай байгаа. Энэ олон юу гэдэг юм туршлагатай улс төрчдийн босгыг давж бид нар энийг оруулж ирж чадахгүй байсан. Ашгүй минь харин Цэцийн дүгнэлт гарлаа. Тийм ээ Лодой. Тийм, тэгэхээр ингээд энэ дээр бид нар ажиллах ёстой гэдэг ийм байр суурьтай байгаа.

Дараагийн нэг зүйл нь яах вэ иргэний эрх зүй дээр нэг ийм юмыг бид нар бас энэ танхимаар бас ойлгочихмоор байгаад байгаа юм. Хэрвээ худал мэдээлэл тараасан бол иргэний эрх зүй дээр байгаа, Иргэний хууль дээр байгаа. 21 дүгээр зүйл дээр худал мэдээлэл тараасан бол худал мэдээлэл тараасан хүн нь тэрийгээ үнэн мэдээлэл юм гэж нотлох үүргийг хүлээдэг. Бид нар эсрэгээр нь ойлгоод байгаа байхгүй юу. Нөгөө хохирсон хүнээр нотлуулах гээд байгаа юм. Үгүй, худал мэдээлэл тараасан хүн өөрөө энийг энэ худал мэдээлэл биш үнэн гэдгийг нотлох үүрэг хүлээнэ. Нотолж чадахгүй бол яг тэр тараасан арга замаараа сэргээнэ гэж байгаа юм.

Жишээ нь Батбаатар гишүүний нэр төрд Пүрэвдорж гишүүн халдсан бол энэ танхимын чуулган дээр сууж байгаад энэ байрны дэмжлэгийг Батбаатар гишүүн аваагүй гэдгээ яг адилхан зарлах ёстой. Тэгж байж энэ хүний нэр төр сэргэнэ. Ийм механизм ажиллах ёстой. Тэрнээс ямар нэгэн бичиг явуулаад, эсвэл танхимаас гараад улс төр шүү дээ хөгшин ойлгож байгаа биз дээ ийм байж болохгүй шүү дээ.

Дээрээс нь ёс зүйн хариуцлага бас энэ дээр бас яригдах ёстой. Ингээд бүгдээрээ ингээд юмнуудаа аягүй сайн ингээд деталийн ярих ёстой цаг нь болсон

гэж бодож байна. Тэгээд Ардчилсан намынхан бас энийг бас босгохыг дэмжиж байгаа юм байна гэж ойлгож байна. Цэцийн дүгнэлтийг хүлээж аваасай гэж хүсэж байна. Тэгээд хариулт бас хэрэггүй.

Н.Учрал: Хүрэлбаатарын. Баасанжаргал гишүүн үг хэллээ.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа.

Гишүүдийг танхимд урья. Одоо Хууль зүйн байнгын хорооны саналаар санал хураалт явуулах гэж байна. Гишүүдийг танхимд урья. Энэ Цэцийн дүгнэлтийг хүлээж авлаа гэхэд 15 хоногийн дотор хуулийн төслийг боловсруулаад Хууль зүйн байнгын хороогоор оруулаад чуулганаар дахиж батална. Тэрнээс биш Эрүүгийн хуулиас тэр гүтгэх, доромжлохыг авч хаячхаад байгаа юм биш шүү дээ. Тийм учраас энэ чинь Цэцийн тайлбарт үндэслээд хуулиа нэмэлт, өөрчлөлт оруулах эрх зүйн орчныг нээж байна гэж ойлгож байгаа. Тийм үү үгүй юу? Гишүүд танхимд урья.

Одоо Хууль зүйн байнгын хорооны саналаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлтгэе.

Энэ Цэцийн дүгнэлтийг хүлээж авсан тохиолдолд хуулийн төсөлд, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах ажлын хэсгийг байгуулна. Ингээд Хууль зүйн байнгын хороогоор ороод Их Хурлын чуулганаар хууль батлах ёстой биз дээ процесс нь дэгийн хуулиараа.

Гишүүд танхимд орж ирье. Санал хураалаа.

1.Эрүүгийн хуулийн 13,14 дүгээр зүйлд, 13-ын 14 биз дээ?

Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлд “Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараасан бол дөрвөн зуун тавин нэгжээс нэг мянга гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас гурван сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “... эрх чөлөө, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэснийг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт.

10 гишүүн зөвшөөрч, 12.3 хувиар санал дэмжигдсэнгүй.

2.Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлд “Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараасан бол дөрвөн зуун тавин нэгжээс нэг мянга гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас гурван сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.” гэж заасан нь Монгол

Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 16 дахь заалтын "... үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх ... эрх чөлөөтэй. ..." гэснийг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт.

10 гишүүн дэмжиж, 12.3 хувиар санал дэмжигдсэнгүй.

3.Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлд "Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараасан бол дөрвөн зуун тавин нэгжээс нэг мянга гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас гурван сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ." гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 17 дахь заалтын "төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. ..." гэснийг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана. Санал хураалт.

11 гишүүн дэмжиж, 13.6 хувиар санал дэмжигдсэн буюу дэмжээгүй саналыг дэмжсэнгүй.

4.Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлд "Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараасан бол дөрвөн зуун тавин нэгжээс нэг мянга гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас гурван сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ." гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Үндсэн хуульд хууль ... бүрнээ нийцсэн байвал зохино." гэснийг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт.

8 гишүүн дэмжиж, 9.9 хувиар санал дэмжигдсэнгүй.

Хууль зүйн байнгын хорооны саналаар санал хурааж дууслаа.

Байнгын хорооны саналыг, Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжээгүй тул Цэцийн дүгнэлтийг Их Хурал хүлээж авч байна гэж ойлгож болно.

10 дугаар дүгнэлтийг хүлээж авсан тул хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудал. Тэрнээс биш тэр хүний нэр төр, алдар хүндэд халдах, илтэд худал мэдээлэл түгээхийг Эрүүгийн хуулиас бүрэн авчхаад байгаа юм байхгүй шүү дээ. Одоо Их Хурал ажлын хэсгээ байгуулаад Үндсэн хуульд нийцүүлээд хуулийн төслөө боловсруулах ёстой. Ингээд Их Хурлын олонхын болон цөөнхийн бүлэг, зөвлөл, намуудаас нэгдсэн ажлын хэсгийг байгуулаад ажиллах хэрэгтэй. Олонхын бүлгээс Батжаргал дарга яриад энэ Баасанжаргал гишүүнээр ч юм уу ахлуулаад

тэгээд ажлын хэсгээ байгуулаад хурдан хугацаанд шийдэх хэрэгтэй. Ингээд хуулийн ийм цоорхойг ингээд үлдээж болохгүй. Тийм учраас үүнд анхаарал хандуулъя.

Байнгын хорооны дэмжээгүй саналуудыг Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй тул “Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 10 дугаар дүгнэлтийн тухай” Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцлоо.

Цэцийн дүгнэлтийг хүлээж авлаа. Улсын Их Хурлын гишүүдэд талархал илэрхийлье.

19.17 цаг

Дараагийн асуудалд оръё. Гишүүд анхааралтай танхимдаа цуглая.

“Чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Цаг үетэйгээ нийцүүлж цаг хугацаа алдахгүйгээр Эдийн засгийн байнгын хороо чуулганы нэгдсэн хуралдаанд Их Хурлын тогтоолын төслийг “Чиглэл өгөх тухай” Их Хурлын тогтоолын төслийг оруулж ирсэн.

“Чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Лхагвасүрэнгийн Соронзонболд танилцуулна. Соронзонболд гишүүнийг индэрт урья.

Л.Соронзонболд: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгийг үндэслэн боловсруулсан “Чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Эдийн засгийн байнгын хороо 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлсэн “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр баталсан бөгөөд уг тогтоолыг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах чиг үүрэгтэй ажилласан ажлын хэсгээс Үндсэн чиглэлд тусгасан улс орны эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах, Монгол Улсын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, макро эдийн засгийн гол зорилт, үндсэн үзүүлэлтүүдийг сайжруулах хүрээнд эдийн засгийн өсөлтийг 6 хувиас багагүй түвшинд хадгалах, инфляцыг зорилтот интервал тогтворжуулах, эрэлтийн болон нийлүүлэлтийн инфляцыг 5 хувьд хязгаарлах, ядуурлыг 15 хувь хүртэл бууруулах. Түүнчлэн төсвийн урсгал зардал, алдагдлыг бууруулах зорилтуудыг холбогдох эрх бүхий байгууллагууд онцгойлон анхаарч, хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж, Монгол Улсын Их Хурлын чуулганы

хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсэгт заасны дагуу “Чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулжээ.

Тогтоолын төслөөр Засгийн газар, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороонд эдийн засгийн эрх чөлөөг сайжруулах, үнийн өсөлтөөс иргэдийн орлогыг хамгаалах, төсвийн сахилга батыг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээнд чиглэл өгсөн байна.

Байнгын хорооны хуралдаанаар төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Соронзонболд тогтоолын төслийн 2 дахь заалтын 1 дэх дэд заалтад тусгагдсан Монголбанк болон Санхүүгийн зохицуулах хороонд өгсөн үүрэг чиглэлүүд нь үндсэн чиг үүргүүдтэй нь давхардаж байгаа талаар, мөн заалтын 8 дахь дэд заалтад тусгагдсан Хөрөнгийн биржийн талаарх зохицуулалтууд болон тогтоолын төслийн 1 дэх заалтын 2 дахь дэд заалтад тусгагдсан Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн хэрэгжилтэд сөрөг нөлөө үзүүлэхүйц тээвэртэй холбоотой аливаа нэмэлт зохицуулалт, шийдвэр гаргахгүй байх гэсэн зохицуулалтууд төсөлд тусгагдах шаардлагатай эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Жаргалан тогтоолын төслийн үндсэн агуулгыг дэмжиж байгаагаа илэрхийлээд зохицуулалтын хувьд хэт ерөнхий байдлаар тусгагдсан нь уг тогтоолын хэрэгжилтэд сөргөөр нөлөөлөх, хэрэгжилтийг үнэлэх боломжгүй болж байгаа талаар саналаа хэлж, төслийг боловсруулсан ажлын хэсгээс тогтоолын төслийн талаар асуулт асууж, хариулт авлаа.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцээд төслийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулахад 55.6 хувийн саналаар хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлт, тогтоолын төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарлаа хандуулсанд баярлалаа.

Н.Учрал: Гишүүд баярлалаа. Иргэдийг үнийн өсөлтөөс хамгаалах чиглэлээр тогтоолын төслийг Ганзоригийн Тэмүүлэн гишүүн, Батжаргалын Заяабал гишүүн, Соронзонболд гишүүд гээд гишүүд бас санаачилж Эдийн засгийн байнгын хороонд танилцуулсан. Инфляц өнгөрсөн сарын байдлаар Монголбанкны барих ёстой түвшнээс өндөр 8.2 хувьтай байна. 2024 оны 10 дугаар сард нийт 313 барааны үнэ өсөлттэй байсан бол өнөөдрийн байдлаар 406 барааны үнэ өсөлттэй байна. Эдийн засгийг тэдэн хувь өслөө гэж ярьж байгаа мөртөө бид нар үнийн өсөлт өрх гэрт ямар дарамт учруулж байгаа вэ гэдгийг ярих цаг болсон. Тийм учраас Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Засгийн газарт нийт 16 ажлаар үүрэг чиглэл өгч байгаа. Энэ үүрэг чиглэлийн мөрөөр Их Хурлын гишүүд ажиллана.

Тэгээд Монголбанкны өөрийнх нь алдагдал 6 жилийн дотор 7.5 их наяд болсон. Зохих арга хэмжээ авах хэрэгтэй. Санхүүгийн зохицуулах хороо, ББСБ-ын тоо 577-д хүрээд байна. Лизингийн үйлчилгээ хэмээх нэрийдлээр мөнгө хүүлэлтийн үйл ажиллагаа явуулж байна. Иргэдийг үнийн өсөлтөөс хамгаалах чиглэлээр бодлого боловсруулж ажиллах зайлшгүй шаардлага байна. Сагсны

эхний 10 бүтээгдэхүүний дунджаар инфляц тогтоогоод байгаа болохоос биш яг өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт өрхийн амьжиргаанд нөлөөлж байна.

Тийм учраас Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Засгийн газарт үүрэг чиглэл, 16 чиглэлээр өгч байгаа энэ тогтоолын хүрээнд.

Ингээд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж гишүүд асуулт асууж, үг хэлнэ. Нэрсээ өгье.

Асуулт асуух, үг хэлэх гишүүд байхгүй байна. Сая Байнгын хороон дээр нэлээд бас сайтар хэлэлцсэн. Тодорхой саналуудыг тогтоолын төсөлд тусгасан гэж ойлгосон.

Гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа.

Одоо Байнгын хорооны саналаар санал хураалтыг явуулна. Гишүүд санал хураалтад бэлтгэе.

Энэ тогтоолын хүрээнд зах зээл дэх төрийн оролцоог бууруулах, аж ахуйн нэгжүүдэд үүсээд байгаа хүндрэл, саадуудыг арилгах, хууль давсан журмуудыг цуцлах арга хэмжээг Засгийн газарт үүрэг өгсөн. Үүнтэй холбогдуулаад аймаг, орон нутгийн удирдлагууд анхаарах хэрэгтэй. Зах зээлд төрийн оролцоог бууруулах Их Хурлын бодлогыг хэрэгжүүлж ажиллах хэрэгтэй. Энэ бол Их Хурлын тогтоол батлах гэж байна шүү. Тийм учраас зах зээл дэх төрийн оролцоог бууруулах бодлогыг хэрэгжүүлж ажиллах нь бүх түвшинд энэ ажлыг үйлдэл болгох хэрэгтэй. Энэ тогтоолоор тухайлаад барилгын салбарт бас үүрэг өгч байгаа шүү. Төрийн буруугаас болоод Улсын комисс ажиллаагүй, техникийн нөхцөлийг нь олгоогүй улс орны хэмжээнд бараг 600 гаруй барилга байгууламж байна шүү дээ. Тэгээд хүний хөрөнгө мөнгийг аваачаад царцаачихсан. Авах бол аваад, авахгүй бол авахгүй гэдэг шийдвэрээ гаргах хэрэгтэй.

Тийм учраас одоо энэ барилга байгууламж барьчихсан 600 гаруй объектууд дээр шаардлагатай бол зөвшөөрлийг нь өгөөд үйл ажиллагааг нь идэвхжүүлэх ажил руу орохгүй бол зах зээл дээр ингээд царцчихсан байгаа олон объектууд байна. Тэгээд зарим нь дотор нь орон сууц аваад одоо хүртэл орон сууцынхаа гэрчилгээг аваагүй айлууд хүртэл байна шүү дээ. Ингээд төр өөрсдийнхөө буруугаас болж хүнд суртал үүсгэхээд эргээд эцэст нь хувийн хэвшилд дарамт үзүүлдэг энэ байдлыг энэ тогтоолоор бас тодорхой чиглэл өгч байгаа шүү гэдгийг бас хэлье.

Тийм ч учраас энэ зах зээл дэх төрийн оролцоог бууруулах, хүнд суртлаас чөлөөлөх, олон улсад хэрэглэж байгаа энэ “red tape reduction” хөтөлбөрийг манайд хэрэгжүүлэх чиглэлээр Их Хурлын даргын захирамж гарсан. Энэ захирамжийн хүрээнд бид нар холбогдох байгууллагуудад үүрэг, чиглэл өгнө өө гэдгийг хэлье. Тэгээд энэ тогтоолыг хэрэгжүүлэх хүрээнд гишүүдээр ахлуулсан ажлын хэсгийг байгуулж, чуулганы завсарлагаагаар ажиллах болно. Энэ дээр нам, эвслийн төлөөллүүдийг төлөөллийг нь хангаж Их Хурлын даргын захирамжаар ажлын хэсгийг маргааш байгуулна гэдгийг хэлье. Иргэдийг үнийн өсөлтөөс хамгаалах

тогтоол Байнгын хорооны хуралдаанаар дэмжигдсэн. Одоо Байнгын хорооны саналаар санал хураалтыг явуулна.

Байнгын хорооны саналаар иргэдийг үнийн өсөлтөөс хамгаалах тухай Засгийн газар, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороонд “Чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт.

46 гишүүн дэмжиж, 56.8 хувиар санал дэмжигдлээ.

Тогтоолын төслийг баталлаа. Улсын Их Хурлын гишүүд, Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны гишүүдэд талархал илэрхийлье.

19.26 цаг

Баталсан тогтоолын эцсийн найруулгыг сонсоно.

Дараагийн асуудалд оръё.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 46.1.3-д Улсын Их Хурал Энэ хуулийн 46.1.2-т заасан хууль, тогтоолын эцсийн найруулгатай танилцаж ёсчлохыг зөвшөөрөх гэж заасны дагуу тогтоолын эцсийн найруулгыг Байнгын хороод бэлтгэж, Улсын Их Хуралд танилцуулахад бэлэн болсон байна.

1.“Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн найруулга дээр саналтай гишүүд байна уу?

Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. Тэмүүлэн гишүүнд үг өгье.

Г.Тэмүүлэн: Дарга энэ Үндсэн чиглэл дээр нэг техникийн шинж чанартай бас алдаа гарчихсан байгаад байгаа. 2, 3 дугаар асуултын 1.2.1.8 болон 1.2.1.13-ыг нэгтгэн найруулах хэрэгтэй байгаад байгаа. Нэг заалтыг хоёр болгоод биччихсэн байгаа. Уг нь зүгээр техникийн найруулгын засвараар аваад хасчих ёстой байсан зүйлийг техникийн ийм алдаа гарчихсаныг бас нэгтгэн найруулах чиглэл өгөөч л гэсэн чиглэл авах гэсэн юм.

Н.Учрал: Тэмүүлэн гишүүний саналыг редакцын засвартайгаар тусгах хэрэгтэй.

“Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндэслэл үндсэн чиглэл баталсантай холбогдуулж авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн найруулга дээр саналтай гишүүд байна уу?

Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

“Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Худалдааны түр хэлэлцээр соёрхон батлах тухай хуультай холбогдуулж боловсруулсан Их Хурлын тогтоолын төсөл байгаа.

“Оюу толгой бүлэг ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах, хүртэх өгөөжийг нэмэгдүүлэх хүрээнд хийсэн тусгай шалгалт, нээлттэй сонсголын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Засгийн газарт чиглэл өгөх тухай буюу Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай тогтоолын төсөл. Энийг сонсгох уу маргааш сонсох уу? Эрдэнэсийн санг? Бэлтгэл ажлыг хангуулаад маргааш сонсьё.

19.29 цаг

Өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

Маргааш өглөө 10 цагт чуулганы нэгдсэн хуралдаантай. Өнөөдрийн чуулганы хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

19.30 цаг

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ*

Д.ОТГОНДЭЛГЭР

